



ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС  
ХӨРӨНГИЙГ ИРГЭНИЙ ЖУРМААР НЭХЭМЖЛЭХ,  
НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР  
НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

**2025**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

**I сар**

Улаанбаатар хот

**Судалгааг захиалагч:**

Хууль зүй, дотоод хэргийн яам

**Судалгааг хянасан:**

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,  
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

**Судалгааг удирдсан:**

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,  
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

**Судалгааг гүйцэтгэсэн:**

Б.Ариунжаргал

Эрүүгийн эрх зүй, криминологийн  
секторын эрхлэгч (LL.M)

Х.Буянбат

Эрдэм шинжилгээний ажилтан

Б.Баярмаа

Нийтийн эрх зүйн секторын  
Эрдэм шинжилгээний ажилтан

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	6
СХЕМИЙН ЖАГСААЛТ.....	6
УДИРТГАЛ.....	7
НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ.....	9
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ 10	
ГУРАВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮНЭЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ ....	12
3.1. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн зорилго, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томьёоны тайлбарын тухай зохицуулсан тус хуулийн төслийн 1-4 дүгээр зүйл.....	12
1. “Зорилгод хүрэх байдал” болон “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	12
2. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	15
3.2. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, хураан авах, нөхөн төлүүлэх зарчмын тухай зохицуулсан тус хуулийн 5-6 дугаар зүйл	
.....	21
1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал .....	21
2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал .....	21
3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	22
3.3. Хууль бус хөрөнгө шалгах, хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогчийн тухай зохицуулсан тус хуулийн 7-17 дугаар зүйл.....	24
1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал .....	24
2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал .....	25
3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	26
3.4. Хууль бус хөрөнгө хураан авах ажиллагаанд хүсэлт, гомдол гаргах тухай зохицуулсан тус хуулийн 18-24 дүгээр зүйл .....	38
1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал .....	38
2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал .....	39
3.5. Нотлох баримтын тухай зохицуулсан тус хуулийн 25-27 дугаар зүйл.....	40
1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал .....	40
2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал .....	40
3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	41
3.6. Хууль бус хөрөнгийг шалгах ажиллагааны тухай зохицуулсан тус хуулийн 28-51 дүгээр зүйл .....	43

1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал .....	43
2. "Практикт хэрэгжих байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	44
3. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	46
3.7. Хөрөнгө шалгах ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулах тухай зохицуулсан тус хуулийн 52 дугаар зүйл .....	50
1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал .....	50
2. "Практикт хэрэгжих байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	50
3.8. Шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын тухай зохицуулсан тус хуулийн 53-54 дүгээр зүйл .....	51
1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал .....	51
2. "Практикт хэрэгжих байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	51
3. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	52
3.9. Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай зохицуулсан тус хуулийн 55-61 дүгээр зүйл.....	53
1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал .....	53
2. "Практикт хэрэгжих байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	54
3. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	54
3.10. Олон улсын хамтын ажиллагааны тухай зохицуулсан тус хуулийн 58-62 дугаар зүйл .....	55
1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал .....	55
2. "Практикт хэрэгжих байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	55
3.11. "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	56
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ .....	60
ЭХ СУРВАЛЖ .....	62

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
НАТХБХХАНТтХ	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль
ХБХХАНТНАТтХ	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ЭЗИТБДтХ	Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хуулийн төслийн бүтэц .....	10
Хүснэгт 2. Хуулийн төслөөс үнэлэх хэсэг .....	12
Хүснэгт 3. Монгол Улсын авлигын индекст өгсөн үнэлгээ .....	13
Хүснэгт 4. Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал .....	17
Хүснэгт 5. Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаатай холбоотой нэр томьёо .....	20
Хүснэгт 6. Хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаатай холбоотой нэр томьёо .....	20
Хүснэгт 7. Хөрөнгө хураах ажиллагааны мөрдөгчийн бүрэн эрхийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай харьцуулсан нь.....	28
Хүснэгт 8. Хөрөнгө хураах ажиллагааны оролцогчын эрх, үүргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай харьцуулсан нь.....	30
Хүснэгт 9. Холбогдогч .....	36
Хүснэгт 10. Хууль бус хөрөнгийг шалгах тодорхой ажиллагааны тухай зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай харьцуулсан нь .	46
Хүснэгт 11. Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ .....	56

## СХЕМИЙН ЖАГСААЛТ

Схем 1. Хууль бус хөрөнгө шалгах ажиллагаанд гомдол гаргах .....	38
Схем 2. Хууль бус хөрөнгө хураан авах ажиллагаанд хүсэлт, гомдол гаргах .....	39
Схем 3. Хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа /нотлох баримт цуглуулах/ .....	40
Схем 4. Хууль бус хөрөнгө шалгах ажиллагааг эхлүүлэх .....	43
Схем 5. Хууль бус хөрөнгө шалгах ажиллагаан дахь прокурорын оролцоо .....	44
Схем 6. Хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа /Хялбаршуулсан журмаар явуулах/....	50
Схем 7. Прокурорын шийдвэр .....	51
Схем 8. Иргэний хэргийн шүүх нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх .....	53
Схем 9. Хууль бус хөрөнгө хураан авах /Олон улсын хамтын ажиллагаа/....	55

## УДИРТГАЛ

**Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ын Зорилго 5-д “...хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.”<sup>1</sup> гээд Зорилт 5.6-д “Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.” хэмээн зааж Зорилтыг хэрэгжүүлэх I үе шат буюу 2021-2030 оны хугацааг “авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлэх үе” гэж тодорхойлжээ. Мөн **Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050”** Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны зорилт 5.6-д “Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.” гээд тус зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг “Авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг чангатгаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, авлигын хэргийг хянан шалгах, шийдвэрлэхтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.”<sup>2</sup> хэмээн заажээ.**

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)”-ийн зорилт 4.3-т “Авлигын улмаас олсон хөрөнгө, орлогыг илрүүлэх, мөнгө угаах эрсдэлийг бууруулж, хуулийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.” гээд тус зорилтын 4.3.1-т “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, ашиг хүртэгчийн мэдээллийг тогтмол шинэчилж, олон нийтэд нээлттэй болгоно. Мэдээлэл ирүүлээгүй хуулийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлагыг чангатгана.” гэж, Зорилт 6.1-ийн 6.1.4-т “Хөрөнгө буцаасан, хураасан, царцаасан хөрөнгийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг бурдүүлнэ.”, Зорилт 6.2-т “Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцыг эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үндэслэл болгон хэрэглэх, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг бусад улс оронтой байгуулах ажлыг эрчимжүүлж, дотоодын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна.”, Зорилт 6.3-т “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн нас барсан, сураггүй алга болсон, оргон зайлснаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох тогтолцоог бурдүүлнэ.”, Зорилт 6.4-ийн 6.4.1-т “Орлогоосоо давсан зарлагатай, хөрөнгө, орлогын эх үүсвэрээ нотолж чадаагүй албан тушаалтныг нийтийн албанаас чөлөөлөх, эгүүлэн татах эрх зүйн орчныг бурдүүлнэ.”<sup>3</sup> гэж тус тус заасан байна.**

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.1-ийн 4.2.1.1-т “Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлнэ.”, 4.2.1.2-т “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.”<sup>4</sup> гэж тус тус заажээ.**

Дээр дурдсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого тэргүүтэй бодлогын баримт бичгүүдэд авлигагүй нийгмийг цогцлоон бурдүүлэх, энэ төрлийн гэмт

<sup>1</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211057&showType=1>

<sup>2</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211058&showType=1>

<sup>3</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760139806351&showType=1>

<sup>4</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368388631&showType=1>

хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох тогтолцоог бий болгох тухай нийтлэг байдлаар заасан байна. Үүнтэй холбоотойгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/41 тоот тушаалаар Авлигын эсрэг багц хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулан ажиллаж энэхүү Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийг доор дурдсан дагалдах хуулиудын хамтаар боловсруулжээ. Үүнд:

1. Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай (Анхдагч хууль);
2. Иргэний хуульд нэмэлт оруулах тухай хууль;
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль;
4. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
5. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль;
6. Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
8. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
9. Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.

Уг төсөлд, Хууль тогтоомжийн тухай хуульд заасныг үндэслэн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтооолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх-/ыг баримтлан хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг хийж, гүйцэтгэв.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөх, санал дэвшүүлэх болно.

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ Аргачлалын дагуу дараах үе шаттайгаар судалгаа хийж, тайланг боловсруулав. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө үнэлэх хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохиорх шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж боловсруулах ажил багтсан.

## **НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, Аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонгож төслийн үр нөлөөг үнэллээ. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Практикт хэрэгжих боломж;
4. Харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлт багтана.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн болно. Үүнд:

**“Зорилгод хүрэх байдал”** шалгуур үзүүлэлтийн хүрээнд Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслөөр дэвшиүүлсэн зорилгод хүрч чадах эсэхийг тооцож, тус хуулийн төслийн болон дагалдах хуулийн төслийн зохицуулалтууд нь уг мөн зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэлнэ.

**“Практикт хэрэгжих боломж”** шалгуур үзүүлэлтийг сонгох болсон нь Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл байгаатай холбоотой. Уг шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг үнэлэхэд тохиромжтой байдаг. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөж, хэрэгжүүлэх боломжтой эсэх буюу хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг шалгаж тооцно.

**“Ойлгомжтой байдал”** шалгуур үзүүлэлтийн хүрээнд Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик уялдаатай боловсруулагдсан эсэхийг шалгана.

**“Харилцан уялдаа”** шалгуур үзүүлэлтийн хүрээнд Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэг давхардсан, зөрчилдсөн эсэхийг шалгаж үнэлнэ.

Харин Аргачлалын 6 шалгуур үзүүлэлтээс “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” болон “Зардал” гэсэн 2 шалгуур үзүүлэлтийг энэхүү үнэлгээнд сонгож аваагүй болно.

Түүнчлэн, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тусад нь бие даасан судалгаа хийсэн. Иймд энэ хуулийн төсөлтэй холбогдох зардлын тооцоог тус судалгааны тайлангаас үзнэ үү.

## **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл нь 11 бүлэг, 64 зүйл бүхий дараах бүтэцтэйгээр боловсруулагдсан байна. Үүнд:

### **Хүснэгт 1. Хуулийн төслийн бүтэц**

<b>Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл</b>	
1-р зүйл	Хуулийн зорилго
2-р зүйл	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль тогтоомж
3-р зүйл	Хуулийн үйлчлэх хурээ
4-р зүйл	Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
<b>Хоёрдугаар бүлэг. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх зарчим</b>	
5-р зүйл	Шударга ёсны зарчим
6-р зүйл	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх үйл ажиллагааны зарчим
<b>Гуравдугаар бүлэг. Хууль бус хөрөнгө шалгах, хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогч</b>	
7-р зүйл	Хууль бус хөрөнгийг хураан авах ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага
8-р зүйл	Шүүх
9-р зүйл	Прокурор
10-р зүйл	Мөрдөгч
11-р зүйл	Өмгөөлөгч
12-р зүйл	Холбогдогч
13-р зүйл	Гэрч
14-р зүйл	Иргэний нэхэмжлэгч
15-р зүйл	Шинжээч
16-р зүйл	Мэргэжилтэн
17-р зүйл	Орчуулагч, хэлмэрч
<b>Дөрөвдүгээр бүлэг. Хууль бус хөрөнгө хураан авах ажиллагаанд хүсэлт, гомдол гаргах</b>	
18-р зүйл	Хүсэлт, гомдол гаргах
19-р зүйл	Хүсэлт, гомдол гаргах журам
20-р зүйл	Хүсэлтийг шийдвэрлэх
21-р зүйл	Гомдлыг шалган шийдвэрлэх нийтлэг журам
22-р зүйл	Мөрдөгч, прокурорын шийдвэр, ажиллагаанд гаргасан гомдлыг хянах
23-р зүйл	Шүүхийн шийдвэрт гомдол гаргах
24-р зүйл	Хүсэлт, гомдлыг хавтаст хэрэгт хавсаргах
<b>Тавдугаар бүлэг. Хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааны нотлох баримт</b>	
25-р зүйл	Нотлох баримт
26-р зүйл	Нотлох баримт цуглуулах
27-р зүйл	Нотлох баримтыг үнэлэх
<b>Зургаадугаар бүлэг. Хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа</b>	
28-р зүйл	Хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа явуулах үндэслэл
29-р зүйл	Шалгах ажиллагааны хамрах хугацаа
30-р зүйл	Шалгах ажиллагаа явуулах
31-р зүйл	Шалгах тодорхой төрлийн ажиллагаа
32-р зүйл	Үзлэг хийх
33-р зүйл	Нэгжлэг хийх
34-р зүйл	Тайлбар, мэдүүлэг
35-р зүйл	Тайлбар, мэдүүлгийг газар дээр нь шалгах
36-р зүйл	Таньж олуулах
37-р зүйл	Шинжилгээ хийлгэх

38-р зүйл	Эд хөрөнгө битүүмжлэх
39-р зүйл	Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах
40-р зүйл	Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах
41-р зүйл	Түр хураан авах
42-р зүйл	Түр хураан авсан хөрөнгийг шийдвэрлэх
43-р зүйл	Тодорхой төрлийн ажиллагаа явуулах журам
44-р зүйл	Битүүмжлэх, хураан авах ажиллагаанд хориглох зүйл
45-р зүйл	Шалгах ажиллагааны баримт бичиг
46-р зүйл	Шалгах ажиллагааны хэргийн материал
47-р зүйл	Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах
48-р зүйл	Прокурорын зөвшөөрөл
49-р зүйл	Шалгах ажиллагаа явуулах хугацаа
50-р зүйл	Шалгах ажиллагааны нууцлал, нийтэд мэдээлэх
51-р зүйл	Хөрөнгө шалгах ажиллагааны шийдвэр
<b>Долдугаар бүлэг. Хөрөнгө шалгах ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулах</b>	
52-р зүйл	Хөрөнгө шалгах ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулах
<b>Наймдугаар бүлэг. Шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналт</b>	
53-р зүйл	Прокурорын шийдвэр
54-р зүйл	Шалгах ажиллагааны хэргийн материал
<b>Есдүгээр бүлэг. Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа</b>	
55-р зүйл	Нэхэмжлэл гаргах
56-р зүйл	Шүүх хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай шийдвэр гаргах
57-р зүйл	Хууль бус хөрөнгийг олж авсан этгээдээс хураах
<b>Аравдугаар бүлэг. Олон улсын хамтын ажиллагаа</b>	
58-р зүйл	Хууль бус хөрөнгийг хураан авах асуудлаар харилцах байгууллага
59-р зүйл	Гадаад улсын хүсэлтэд тавигдах шаардлага
60-р зүйл	Гадаад улсаас хүлээн авсан хүсэлтийг биелүүлэх журам
61-р зүйл	Хууль бус хөрөнгийг буцаан олгох, хуваарилах
62-р зүйл	Хүсэлт илгээх журам
<b>Арван нэгдүгээр бүлэг. Бусад зохицуулалт</b>	
63-р зүйл	Мэдээллийн сан, тайлан
64-р зүйл	Бусад зүйл

Хууль тогтоомжийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоохдоо шууд үр дагавар үүсгэж байгаа гол ач холбогдолтой заалтуудыг сонгож авахыг чухалчилдаг. Тийнхүү сонгохдоо тухайн сонгож буй заалт, зохицуулалт нь бодитой судалгаа хийж болохуйц байх, тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинэ чиг үүрэг хүлээлгэж байгаа, эсхүл ямар нэг байгууллага бий болгож буй зохицуулалт хуулийн төсөлд тусгагдаж байгаа бол ийм заалтыг зайлшгүй сонгож авах нь зүйтэй гэж үздэг.

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл учир хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхийг зорьсон болно. Иймд Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг бүхэлд нь хамруулж, Аргачлалын “Зорилгод хүрэх байдал”, “Ойлгомжтой байдал”, “Практикт хэрэгжих боломж”, “Харилцан уялдаа” гэсэн 4 шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөний үнэлгээ хийллээ.

## ГУРАВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮНЭЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхээр сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирих шалгах хэрэгслийг доорх хүснэгтэд үзүүлэв.

### Хүснэгт 2. Хуулийн төслөөс үнэлэх хэсэг

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирих шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл бүхэлдээ	Зорилгод дүн шинжилгээ хийх
2.	Практикт хэрэгжих боломж	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл бүхэлдээ	Практикт хэрэгжих боломжтой эсэхийг үнэлэх
3.	Ойлгомжтой байдал	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл бүхэлдээ	Ойлгомжтой байдлыг шалгах
4.	Харилцан уялдаа	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн зохицуулсан тус хуулийн төслийн 1-4 дүгээр зүйл	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн бөгөөд Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн хамрах хүрээ, төслийн бүтцийг харгалзан дэд хэсгүүдэд хувааж тайланг боловсрууллаа.

**3.1. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн зорилго, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томьёоны тайлбарын тухай зохицуулсан тус хуулийн төслийн 1-4 дүгээр зүйл**

**1. “Зорилгод хүрэх байдал” болон “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Монгол Улсын Их Хурал 1996 онд Авлигын эсрэг хууль, 2002 онд Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг баталж, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих орон тооны бус Үндэсний зөвлөлийг байгуулж ажиллуулсан.<sup>5</sup> Улмаар 2005 онд манай улс НҮБ-ын Авлигын эсрэг конвенцод нэгдэн орж, улмаар 2006 онд Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталсан бөгөөд тус хуулийн дагуу Монгол Улсад анх удаа авлигатай тэмцэх тусгай байгууллага болох Авлигатай тэмцэх газар

<sup>5</sup> Авлигатай тэмцэх газар, Түүхэн замнал <https://iaac.mn/erhem-zorilgo-undsen-zarchim-tuuhen-zarchim>

байгуулагдан 2007 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

2023 онд Транспэрэнси Интернэшнл байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн индекс (АТИ)-ийн дүнгээр Монгол Улс 33 оноо авч, 180 улс орноос 121 дүгээр байрт эрэмбэлэгдсэн. Уг индексээр Монгол Улс 2012-2023 онд дунджаар 36.17 оноо авсан. Сүүлийн 12 жилийн хугацаанд АТИ-ийн дэлхийн дундаж оноо өөрчлөгдөөгүй буюу 43 оноо байна (боломжит 100 онооноос). Дэлхийн улс орнуудын гуравны хоёр нь 50-аас доош оноо авсан нь эдгээр улс орнуудад авлига ноцтой асуудал болсныг илтгэж байна. Мөн шүүхийн тогтолцоо супарч буй дэлхий нийтийн чиг хандлага нь нийтийн албан тушаалтны хариуцлагыг бууруулж, улмаар авлига цэцэглэх боломжийг олгож байгааг Транспэрэнси Интернэшнл байгууллага онцлон тэмдэглэжээ.

Сүүлийн жилүүдэд манай улсад авлигын асуудал ихээхэн анхаарал татсан, зайлшгүй шийдвэрлэх асуудлын нэг болоод байна. Үүнийг авлигын индексэд оноо өгдөг судалгааны байгууллагууд манай улсад 2020-2023 онд өгсөн онооноос харж болох юм.

### **Хүснэгт 3. Монгол Улсын авлигын индексэд өгсөн үнэлгээ<sup>6</sup>**

<b>№</b>	<b>Байгууллага-судалгаа</b>	<b>2020</b>	<b>2021</b>	<b>2022</b>	<b>2023</b>
1	Пи Ар Эс групп – Эрсдэлийн үнэлгээ 2020, 2021	41	37	32	33
2	Ай Эм Ди – Дэлхийн өрсөлдөх чадварын эмхэтгэл, Үзэл бодлын судалгаа 2020, 2021	32	29	30	33
3	Ардчиллын олон талт байдлын төсөл 2020, 2021	34	34	28	25
4	Дэлхийн эдийн засгийн форум – Үзэл бодлын судалгаа	28	34	30	-
5	Бертелсман сан – Шилжилтийн индекс 2020, 2022	37	37	37	37
6	Дэлхийн банк – Улс орны бодлого, институтийн үнэлгээ 2019, 2020	35	-	-	-
7	Эдийн засгийн мэдээллийн нэгж – Улс орнуудын эрсдэлийн үнэлгээ 2020, 2021	33	33	37	37
8	Дэлхийн эрх зүйн төсөл – Хууль дээдлэх ёсны индекс	33	35	35	33
9	Глобал инсайт байгууллага – Улс орнуудын эрсдэлийн түвшин 2019, 2020	35	35	35	35
<b>Дундаж оноо</b>		35	35	33	33

Манай улс авлигын төсөөллийн индексийн дундаж оноогоор:

- 2020 онд 35 оноо авч 180 орноос 111 дүгээр байр;
- 2021 онд 35 оноо авч 180 орноос 110 дугаар байр;
- 2022 онд 33 оноо авч 180 орноос 116 дугаар байр;
- 2023 онд 33 оноо авч 180 улсаас 121 дүгээр байрт тус тус эрэмбэлэгджээ.

Дээрх тоон мэдээнээс харвал, 2022, 2023 онд өмнөх жилүүдтэй харьцуулахад авлигын төсөөллийн индексийн оноо 2-оор буурч, 6-11 байр ухарсан үзүүлэлттэй байна. Авлигын индекс буурч, хэлбэлзэж байгаа нь ардчилсан тогтолцоо бэхжээгүй, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг улс төрийн намуудын төлөвшил муу байгааг шууд харуулж байна.

Тус судалгаанд Ази номхон далайн бүс нутгаас хамрагдсан 31 орны дундаж оноо нь 45 байхад Монгол Улс бүс нутгийн дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Энэхүү судалгаанд хамрагдсан 180 орноос дундаас доогуур орлоготой 50 улсын

<sup>6</sup> Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан номны тоон мэдээнээс, /2020, 2021, 2022 он/

авлигын төсөөллийн индексийн дундаж оноо нь 33 байна. Харин манай улсын хувьд сүүлийн 2 жил 33 оноо нь авсан нь энэ ангилалд багтаж үндэслэл болж байна.

Тиймээс ч төрийн бодлогын баримт бичгүүдэд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар тусгайлан тусгах болсон. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2.7-д "...хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх..." гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан "...нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах..." бүрэн эрхийнхээ хүрээнд "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын "Засаглал"-ын зорилт, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын "Төрийн бүтээмжийн сэргэлт"-ийн зорилтыг тус тус үндэслэн Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтооолоор 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласан.

Төрийн бодлогын баримт бичгүүдэд Монгол Улсад авлигагүй нийгмийг цогцлоон бүрдүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн нас барсан, сураггүй алга болсон, оргон зайлснаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох тогтолцоог бий болгоно гэж тус тус заасан.<sup>7</sup>

Монгол Улс хууль тогтоомжийн хэрэгжилт, хариуцлагын бодлого сул, тодорхой бус, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх байгууллагуудын хоорондын уялдаа хангалтгүй, авлигын гэмт хэрэг, түүнийг дагалдан гардаг мөнгө угаах гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлоогүй, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сул, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх процесс болон хураасан хөрөнгө, орлогыг хяналттайгаар, ил тод эрхлэн удирдах, эрхлэн удирдсанаас олсон орлогыг зөв, ил тод зарцуулах, тайлагнах эрх зүйн орчин тодорхой бус, түүнчлэн авлигын мэдээлэгчийг хамгаалах, нууцлах, урамшуулах талаар хууль тогтоомжгүй байгаа нь авлигын үзүүлэлт доогуур гарах шалтгаануудын нэг болж байна.<sup>8</sup>

Нөгөөтээгүүр, нийтийн албан тушаалтны хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураан авах нөхөн төлүүлэх процесс, үүнээс гадна хураасан хөрөнгө, орлогыг хяналттайгаар, ил тод эрхлэн удирдах, эрхлэн удирдсанаас олсон орлогыг зөв, ил тод зарцуулах, тайлагнах эрх зүйн орчин тодорхой бус, түүнчлэн авлигын мэдээлэгчийг хамгаалах, нууцлах, урамшуулах талаар хууль тогтоомжгүй байна.<sup>9</sup>

Авлигатай тэмцэх гол арга зам нь авлигын улмаас бий болсон хөрөнгийг буцаах буюу хураан авах, нөхөн төлүүлэх бодлого бөгөөд энэхүү бодлогыг шударгаар хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Ялангуяа эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүйд хүргэсэн хуульд заасан үндэслэл бий болсон эсэхийг үл харгалзан гэм буруутай эсэхийг тогтоох, ял шийтгэл оногдуулах асуудлыг хөндөлгүйгээр зөвхөн гэмт хэргийн улмаас олсон буюу хууль бус хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх бодлогыг хэрэгжүүлэх механизм буюу эрх зүйн тодорхой зохицуулалт чухал шаардлагатай болжээ.<sup>10</sup>

<sup>7</sup> Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, 2024 он, 1 дэх тал.

<sup>8</sup> Мөн тэнд.

<sup>9</sup> Мөн тэнд, 6 дахь тал.

<sup>10</sup> Мөн тэнд.

Иймд нийтийн албан тушаалтны гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлого болон хууль ёсны орлогоос давсан, хууль ёсны болохыг тайлбарлаж чадаагүй хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх, процессын зохицуулалтыг тодорхой болгож хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж үзэж Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-д "...Энэ хуулийн зорилго нь нийтийн албан тушаалтны хууль ёсны орлогын эх үүсвэрээс давсан, түүний шууд болон шууд бус өмчлөл, эзэмшилд байгаа, эрхэлж байсан болон эрхэлж байгаа албан тушаалын эрх нөлөөгөөр бий болсон, хууль ёсны эх үүсвэр тодорхойгүй, эсхүл хууль бус аргаар олж авсан эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлогыг хурааж авах, нөхөн төлүүлэх эрх зүйн үндэслэлийг тогтоо замаар нийтийн алба дахь авлигыг таслан зогсоох, дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, авлигагүй нийтийн албыг бий болгоход оршино..." гэж заажээ.

Үүнээс тус хуулийн зорилгыг задлан авч үзвэл:

- Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хурааж авах;
- Нөхөн төлүүлэх эрх зүйн үндэслэлийг тогтоох;
- Нийтийн алба дахь авлигыг таслан зогсоох;
- Дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх;
- Авлигагүй нийтийн албыг бий болгох гэж ерөнхийлөн авч үзэж болох юм.

Хуулийн төслийн зохицуулалтууд нь тус зорилгыг хангахад чиглэсэн байх ёстой. Хуулийн төсөл нь иргэний эрх зүй болон эрүүгийн эрх зүйд холбогдох харилцааг "холимог" байдлаар зохицуулсан байгаа нь тус хуулийг практикт хэрэгжүүлэхэд тулгарч болох нэн тэргүүний асуудал байж болох юм.

## 2. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн 2-р зүйлийн 2.2-т “Бусад хуульд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол энэ хуулийг дагаж мөрдөнө.” гэж заажээ. Ийнхүү заасан нь тус зохицуулалтын тусламжтайгаар хэм хэмжээний зөрчилдөөнийг даван гарна гэж тооцжээ.

Эрх зүйн тогтолцооны нэгдмэл байдлыг хангах үүднээс хэм хэмжээний зөрчилдөөнийг зохицуулах дараах турван зарчим эрх зүйн онолд номлолын түвшинд хөгжж ирсэн. Үүнд:

- **Lex superior derogat legi inferiori:** Давуу хүчин чадалтай буюу дээд эрэмбийн хэм хэмжээ нь доогуур эрэмбийн хэм хэмжээг давамгайлна.
- **Lex specialis derogat legi generali:** Тусгай буюу нарийвчилсан зохицуулалттай хэм хэмжээ ерөнхий зохицуулалттай хэм хэмжээг давамгайлна.
- **Lex posterior derogat legi priori:** Өмнө нь батлагдан хүчин төгөлдөр хэрэгжиж буй хэм хэмжээ нь хожим батлагдсан хэм хэмжээнээс давуу үйлчилнэ.

Дээрх зарчмуудыг манай улсын эрх зүйн тогтолцоо Үндсэн хууль болон хууль тогтоомж боловсруулах салбарын эрх зүйн зохицуулалтдаа тусгасан байдаг. Жишээ

нь, Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл. Ийнхүү хэдий хуульд туссан тул дээрх зарчмууд нь зөвхөн эрх зүйн онолын шалгуур биш. Заавал биелэгдэх хэм хэмжээ юм.

Иймд тус хуулийн төслийн зохицуулалт (тухайн хуулийн төсөл хууль болж батлагдан хэрэгжиж эхэлсэн гэж үзвэл) бусад хуультай зөрчилдсөн тохиолдолд зөвхөн тус хуулийн зохицуулалтыг сонгон хэрэглэх боломжгүй. Тодруулбал, тухайн хуулийн төслийн зохицуулалт нь бусад хуулийн зохицуулалттай зөрчилдсөн тохиолдолд юун түрүүнд *lex superior derogat legi inferiori* зарчмын дагуу хэм хэмжээний эрэмбийн хувьд дээр байрлах хуулийн зохицуулалтыг хэрэглэж тус хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгсэхгүй. Мөн *lex specialis derogat legi generali* зарчмын үүднээс тус хуулийн төслийн зохицуулалтаас илүү нарийвчилсан зохицуулалт бүхий хуулийг хэрэглэх ба түүнчлэн хуулийн төсөл нь өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй бүх хуульд нийцсэн байхыг *lex posterior derogat legi priori* зарчмын дагуу шаардана.

**Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.3-т** “Энэ хуульд тухайлсан харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэхээр прокуророос шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх тус нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх шатанд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэнэ.” гэж заажээ. Энд дурдагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь тус зүйлийн 2.2-т заасан ‘Бусад хууль’ гэдэгт хамаарахгүй гэж ойлгогдохоор байх ч бусад гэдэг нь тухайлан онцолсон тодорхой нэг зүйл, ойлголтоос өөр бүх зүйл гэсэн агуулгыг илэрхийлдэг. Хуулийн төслийн тус заалтад “бусад хууль” гэх үгийг хэрэглэснээр тухайн хуулийн төсөл буюу төслөөр батлагдах хууль болон өөр бусад бүх хууль гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваагдана гэсэн үг юм. Эндээс хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг **хоорондоо зөрчилдэж байгаа** нь харагдаж байна.

Хэм хэмжээний зөрчилдөөн бол хууль хэрэглээний явцад буюу хуулийг хэрэгжүүлэхэд зайлшгүй тулгарах ёстой асуудал биш бөгөөд эрх зүйн актыг батлахдаа хэм хэмжээний зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэхийг зорих нь зүйтэй. Тиймээс ч Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.1-д зааснаар хуулийн төсөлд тавигдах нийтлэг шаардлагад хуулийн төслийн агуулга нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байхыг шаарддаг. Мөн энэ нь Үндсэн хуульд нийцүүлж буй явдал юм. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1-д “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэж заасан байдаг.

Иймд хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хууль болон Хууль тогтоомжийн тухай хуульд нийцэхгүй байна. Мөн тус зохицуулалтууд нь хоорондоо уялдахгүй, логик зөрчилтэй байна.

**Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д** “гэмт хэрэг гэж нийтийн албан тушаалтны холбогдсон гэмт хэргийг” гэж заажээ. Тус заалтын харилцан уялдаатай байдлыг шалгая.

Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлд гэмт хэргийн ойлголт, шинж буюу гэмт хэргийг “Энэ хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс

үйлдэхүйг гэмт хэрэгт тооцно.” гэж заасан байх бөгөөд тус хуулийн 1.2 дугаар зүйлийн 1-д “Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно.” Гэж, мөн зүйлийн 2-т “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй.” гэж тус тус заажээ. Энэ нь гэмт хэргийг зөвхөн Эрүүгийн хуулиар тодорхойлно гэсэн агуулгыг илэрхийлэх бөгөөд Эрүүгийн хуулийн хууль ёсны зарчмын илрэл юм.

Эрүүгийн хууль бол бүрэн хэмжээгээр төрөлжүүлж нэгтгэсэн хууль бөгөөд Монгол Улсын эрүүгийн эрх зүйн цорын ганц эх сурвалж байх учиртай.<sup>11</sup> Энэ нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн уламжлал юм.<sup>12</sup> Үүнээс Эрүүгийн хуулиас бусад хуулиар гэмт хэргийг тодорхойлох боломжгүй болох нь харагдаж байна. Иймд гэмт хэргийг тодорхойлсон хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт Эрүүгийн хуульд нийцэхгүй байна.

**Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “хууль бус орлого”** гэж хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй, эсхүл тайлбарласан нь нотлогдоогүй **хөрөнгийг** гэж тодорхойлжээ. Энд хууль бус орлого гэж хууль ёсны гэдгийг нь тайлбарлаагүй, нотлоогүй хөрөнгийг ойлгохоор заажээ. Гэтэл хууль ёсны гэж юуг, хэрхэн ойлгох нь тодорхойгүй байна. Үүнээс үүдэж хууль ёсны орлого, хууль ёсны хөрөнгө гэж юу болох нь хангалттай тодорхой биш хэвээр байна.

4.1.3.“хууль бус орлогоос бий болсон хөрөнгө” гэж **хууль бус орлогын** үр дүн, үр шимээр бий болсон хөрөнгө, **хууль бус орлогоор** олсон хөрөнгө, эдгээр хөрөнгийн үр шимээр олсон хөрөнгө, хууль бус орлогын хэлбэр өөрчлөгдөх юм уу хувирснаас бий болсон хөрөнгийг (хууль бус орлого хууль ёсны хөрөнгөтэй нийлж, хувирч, өссөн тохиолдолд хууль бус орлогоос бий болсон хэсгээр хязгаарлана);

4.1.4.“хууль бус хөрөнгө” гэж **хууль бус орлого** болон хууль бус орлогоос бий болсон хөрөнгийг ойлгох бөгөөд тухайн нөхцөл байдлаас үл хамааран энэ хуульд заасан журмаар хууль ёсны орлогоор олж авах үндэслэлгүй хөрөнгө, түүний иж бүрдэлд хамаарах хөрөнгө, энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө буюу дараа нь олж авсан, түүнчлэн тухайн хөрөнгийг ашигласнаас олсон, бий болсон хөрөнгө, **орлогыг**;

Ийнхүү “хууль бус орлого” гэх ойлголт хангалттай тайлбарлагдаагүй учир хуулийн төслийн 4.1.3, 4.1.4-т заасан нэр томьёоны тайлбар хангалттай тайлбарлагдах боломжгүй болжээ. Өөрөөр хэлбэл, хуулийн төсөл доторх уялдаа холбоо алдагдсан байна.

#### Хүснэгт 4. Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх,	Хуулийн төслийн нэр нь “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай” бөгөөд энэ нь тухайн зохицуулж буй харилцаандаа хамааралтай байна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн зарим нэр томьёо өөр хоорондоо зөрчилдэж байх бөгөөд тус нэр томьёог дор дэлгэрэнгүй судлан үзсэн болно.

<sup>11</sup> С.Жанцан , Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол, (Уб, 2019), 127 дахь тал.

<sup>12</sup> С.Нарангэрэл, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, (Уб, 1999), 33 дахь тал.

<p>хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх</p>	<p><b>Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо бусад хуулийн төслийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх:</b></p> <p>Төслийн 4.1.5-д "...“хөрөнгө” гэж бүх төрлийн эдийн болон эдийн бус хөрөнгө ... хувиргасан буюу холилдсон эд зүйлс, <b>виртуал хөрөнгийг...</b>” гэж тодорхойлжээ. Харин тус хуулийн төслийн дагалдах хуулийн төсөл болох “Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хууль”-ийн төслийн 3.1.1-д "...“хөрөнгө” гэж бүх төрлийн эдийн болон эдийн бус хөрөнгө ... хувиргасан буюу холилдсон эд зүйлс, <b>криптовалютыг...</b>” гэж тус тус тодорхойлжээ.</p> <p>Өөрөөр хэлбэл, тус хоёр хуулийн төсөлд “хөрөнгө” гэх ойлголтыг ижил байдлаар тодорхойлохыг оролдсон байх боловч “виртуал хөрөнгийг”, “криптовалютыг” гэж ялгаатай байдлаар тодорхойлсон нь өөр хоорондоо зөрчилдөж байна. Үүнийг өөр хооронд нь нийцүүлэх нь зүйтэй.</p>
	<p><b>Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх:</b></p> <p>Төслийн 58.3-т "...Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний хүрээнд..." гэж заажээ. Харин ЭХХШТХ, ИХШХШТХ-ийн холбогдох зохицуулалтад “эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ” гэж заасны дагуу тус хуулийн төслийн дээрх нэр томьёог бусад хуулийн нэр томьёотой нийцүүлэн “эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ” гэж өөрчлөх нь зүйтэй.</p>
<p>Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх</p>	<p><b>Хуулийн төслийн зүйл, заалт бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх:</b></p> <p>Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд “Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ”-ний зохицуулалтыг тусгасан бөгөөд тус хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь энэ хуульд заасан ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэнэ” гэж заасны дагуу тус албадлагын арга хэмжээ нь эрүүгийн хариуцлагын нэг төрөл юм.</p> <p>Гэтэл ХБХХАНТНАТХ-ийн төслөөс харвал нийтийн албан тушаалтны гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах агуулгыг илэрхийлж байх бөгөөд энэ нь Эрүүгийн хуульд заасан хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээний зохицуулалттай ижил агуулгатай.</p> <p>Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор бусдын хөрөнгө, орлогыг хураах нь эрүүгийн эрх зүйн хууль ёсны зарчмын дагуу гагцхүү Эрүүгийн хуулиар зохицуулагдах ёстой. Гэтэл Эрүүгийн хуульд заасан хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээтэй ижил агуулгаар Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөлд тусгасан нь Эрүүгийн эрх зүйн хууль ёсны зарчимтай зөрчилдөж байна гэж үзэж болох юм.</p>

	<p><b>Хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо нийцэж байгаа эсэх:</b></p> <p>Төслийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт "Мөрдөгч нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, <b>тодорхой төрлийн мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр явуулна</b>." гэж мөн төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт "Мөрдөгч хаалттай болон хязгаарлалттай мэдээлэл эсэхээс үл хамааран эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий аливаа мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авна." гэж тус тус заасан нь өөр хоорондоо зөрчилдэж байна.</p> <p>Учир нь төслийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт мөрдөгч прокуророос зөвшөөрөл авсны үндсэн дээр баримт бичиг гаргуулан авах ажиллагааг хийхээр заасан байхад төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт прокуророос зөвшөөрөл авахгүйгээр хаалттай болон хязгаарлалттай мэдээлэл эсэхээс үл хамааран хэрэгт ач холбогдол бүхий аливаа мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авахаар зохицуулжээ.</p>
	<p><b>Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх:</b></p> <p>Хуулийн төсөлд нэг нэр томьёог өөр өөрөөр бичсэн байна. Тухайлбал, хуулийн төслийн хэд хэдэн зохицуулалтад 1/ хууль бус хөрөнгө хураан авах ажиллагаа, 2/ хууль бус хөрөнгийг хураан авах ажиллагаа, 3/ хөрөнгө хураан авах ажиллагаа, 4/ хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаа гэж 4 янзаар бичсэн байна. Иймд ялгамжтай байдлаар бичигдсэн зохицуулалтуудыг доорх хүснэгтэд дэлгэрэнгүй харуулсан болно.</p>

**Хүснэгт 5. Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаатай холбоотой нэр томьёо**

<b>№</b>	<b>Нэр томьёо</b>	<b>Зүйл</b>	<b>Заалт</b>
1.	Хууль бус хөрөнгө хураан авах ажиллагаа	Төслийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг	-
2.	Хууль бус хөрөнгийг хураан авах ажиллагаа	Төслийн 1 дүгээр зүйлийн 1.2, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг	Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7, 4.1.16 дахь заалт
3.	Хөрөнгө хураан авах ажиллагаа	Төслийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.10, 14.11, 15 дугаар зүйлийн 15.4, 16 дугаар зүйлийн 16.1, 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг	Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.13, 17 дугаар зүйлийн 17.3.5 дахь заалт
4.	Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаа	Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг	-
Хуулийн төслийн 1.2-т "... нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаа (цаашид "хууль бус хөрөнгийг хураан авах ажиллагаа" гэх)..." гэж заасан бөгөөд хуулийн төслийн дээрх зохицуулалтуудыг хооронд нь уялдуулан, тус хуулийн төслийн нэр томьёог нэг мөр болгон жигдлэх нь зүйтэй.			

Мөн тус хуулийн төсөлд хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаатай холбоотой нэр томьёог өөр өөрөөр бичсэн байна. Тухайлбал, хуулийн төслийн хэд хэдэн зохицуулалтад 1/ Хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа, 2/ Хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа, 3/ Хөрөнгө шалгах ажиллагаа, 4/ шалгах ажиллагаа гэж 4 янзаар бичсэн байна. Иймд ялгамжтай байдлаар бичигдсэн зохицуулалтуудыг доорх хүснэгтэд дэлгэрэнгүй харуулсан болно.

**Хүснэгт 6. Хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаатай холбоотой нэр томьёо**

1.	Хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа	Төслийн 5 дугаар зүйлийн 5.3, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг	Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.15 дахь заалт
2.	Хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа	Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг	-
3.	Хөрөнгө шалгах ажиллагаа	Төслийн 10 дугаар зүйлийн 10.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 26 дугаар зүйлийн 26.1, 29 дүгээр зүйлийн 29.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, 32 дугаар зүйлийн 32.1, 33 дугаар зүйлийн 33.1, 34 дүгээр зүйлийн 34.1, 36 дугаар зүйлийн 36.1, 37 дугаар зүйлийн 37.1, 41 дүгээр зүйлийн 41.1, 42 дугаар зүйлийн 42.1, 50 дугаар зүйлийн 50.2, 51 дугаар зүйлийн 51.1, 52 дугаар зүйлийн 52.1, 52.3, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг	Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.1.2, 11.1.3, 11.1.4, 11.1.5, 11.1.6, 11.1.7, 11.1.9, 12 дугаар зүйлийн 12.1.4, 12.1.7, 12.1.8, 12.2.3, 16 дугаар зүйлийн 16.3.1, 16.3.2, 16.3.3, 63 дугаар зүйлийн 63.2.1 дэх заалт

4.	Шалгах ажиллагаа	<p>30 дугаар зүйлийн 30.1, 30.4, 30.6, 30.7, 30.8, 30.9, 30.12, 45 дугаар зүйлийн 45.1, 46 дугаар зүйлийн 46.2, 46.5, 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 49 дүгээр зүйлийн 49.1, 49.3, 50 дугаар зүйл, дахь хэсэг, 53 дугаар зүйлийн 53.4, 53.5, 53.6, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг</p>	<p>Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.17, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4, 10.1.7, 10.1.9, 12 дугаар зүйлийн 12.1.1, 54 дүгээр зүйлийн 54.1.1 дэх заалт</p>
----	------------------	--	--

Хуулийн төслийн 28.1-д "...Хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа (цаашид "шалгах ажиллагаа" гэх)..." гэж, мөн төслийн 30.1-д "...хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа (цаашид "шалгах ажиллагаа" гэх)..." гэж давхардуулан заасан байна. Тус зохицуулалтыг хооронд нь уялдуулж (цаашид "шалгах ажиллагаа" гэх) гэснийг тус ойлголтыг хуулийн төсөлд тусгасан эхний зохицуулалтад оруулах. Мөн хуулийн төслийн энэхүү нэр томьёог нэг мөр болгон жигдлэх нь зүйтэй.

### **3.2. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх зарчмын тухай зохицуулсан тус хуулийн 5-6 дугаар зүйл**

#### **1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт "Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх зарчим"-ыг тусгасан бөгөөд тус зарчим нь тус хуулийн төслийн 1.1-д "...Энэ хуулийн зорилго нь нийтийн албан тушаалтны хууль ёсны орлогын эх үүсвэрээс давсан, түүний шууд болон шууд бус өмчлөл, эзэмшилд байгаа, эрхэлж байсан болон эрхэлж байгаа албан тушаалын эрх нөлөөгөөр бий болсон, хууль ёсны эх үүсвэр тодорхойгүй, эсхүл хууль бус аргаар олж авсан эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлогыг хурааж авах, нөхөн төлүүлэх эрх зүйн үндэслэлийг тогтоох..." гэж заасан зорилгод хүрэхэд чиглэсэн зохицуулалт байна. Гэхдээ тус зохицуулалтуудад ойлгомжтой байдал, харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэд хэдэн асуудал тогтоогдсон бөгөөд тухайн асуудлыг холбогдох шалгуур үзүүлэлтийг үнэлсэн хэсэгт дэлгэрэнгүй бичсэн болно.

#### **2. "Практикт хэрэгжих байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Хуулийн төслийн хоёр дугаар бүлэгт заасан нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх зарчим нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг судлан үзэхэд:

Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

- 6.1.1. аливаа хөрөнгө хууль ёсны эх үүсвэртэй байх;
- 6.1.2. нийтийн албан тушаалтан хууль ёсны орлогоос давсан хэмжээний хөрөнгийнхөө эх үүсвэрийг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй, эсхүл тайлбарласан нь нотлогдоогүй бол уг хөрөнгийг хууль бус гэж үзэх;
- 6.1.3. нийтийн албан тушаалтнаас хураан авсан, нөхөн төлүүлсэн хууль бус хөрөнгийг улсын орлого болгох, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;
- 6.1.4. хууль бус хөрөнгө хууль ёсны хөрөнгөтэй нийлсэн, холилдсоны үр дүнд бий болсон хөрөнгөөс зөвхөн хууль бус хэсгийг хураан авах;

- 6.1.5. хууль бус хөрөнгийг хураан авахдаа түүнийг хууль бус болохыг мэдээгүй, мэдэх боломжгүйгээр хууль ёсны дагуу хийсэн хэлцлийн үндсэн дээр шилжүүлэн авсан өмчлөгч, эзэмшигчийн эрхийг хамгаалах;
- 6.1.6. нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө хууль ёсоор бусдын өмчлөлд шилжсэн бол тухайн хөрөнгийг үнэлж нийтийн албан тушаалтны хувьд ногдох, хураан авахыг хуулиар хориглоогүй хөрөнгөөс нөхөн төлүүлэх;
- 6.1.7. тухайн хөрөнгийг хууль ёсны эх үүсвэргүй болохыг мэдсээр байж авсан болох нь тогтоогдвол хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлсэн хэлцлийг хүчингүйд тооцож, тухайн хөрөнгийг хураан авах;
- 6.1.8. нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах үндэслэлийг тодорхойлох, хураах ажиллагааг зөвхөн шүүхэд талууд мэтгэлцэх журмаар хэрэгжүүлэх;
- 6.1.9. хууль бус хөрөнгө бий болсон цаг хугацааг нийтийн албан тушаалтны албан тушаалын бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлсэн болон албан тушаалын бүрэн эрх, чиг үүрэг дууссанаас хойших 10 жилийн хугацаатай заавал хамтатган авч үзэх;
- 6.1.10. нийтийн албан тушаалтан тухайн хууль бус хөрөнгө өөрийн өмчлөл, эзэмшилд байгааг мэдсэн, мэдэх ёстой байсан нь хөрөнгийг нөхөн төлбөргүй хураан авах гэм буруугийн үндэслэл гэж үзэх бөгөөд энэхүү санаа зорилгыг нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг удирдсан, хянасан үйл баримт, нөхцөл байдлаас дүгнэн тогтоохыг зөвшөөрөх” гэж тус тус заажээ.

Төслийн 6 дугаар зүйлд нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгасан мэт боловч тус зохицуулалтууд нь зарчмын шинжийг агуулаагүй байна.

Эрх зүйн зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэхэд эрх зүйн зарчим шийдвэрлэх нөлөө үзүүлж, тэдгээрийн гол эх үндэс нь болно. Нийгмийн амьдралын хэрэгцээ шаардлагыг хангаж түүний харилцааг зохицуулахад баримтлах хууль зүйн үндсэн чиглэмжийг эрх зүйн зарчим гэнэ.<sup>13</sup>

Гэтэл төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.10 дахь заалтад заасан нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд баримтлах зарчмууд нь тухайн харилцааг зохицуулахад баримтлах хууль зүйн үндсэн чиглэмж, эрх зүйн зарчим гэхээс илүүтэй зохицуулалт агуулсан хэм хэмжээ байх тул төслийн дээрх зохицуулалт нь зарчмын хувьд практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна.

### **3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайг шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоогоогүй нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.” гэж шударга ёсны зарчмыг тодорхойлж заажээ. Тус зохицуулалтын агуулгыг авч үзвэл, гэм буруутай нь шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоогоогүй байхад иргэний хөрөнгийг хураах боломжтой байдлаар тусгажээ. Өөрөөр хэлбэл, нийтийн албан тушаалтны хөрөнгийг хураахдаа тухайн нийтийн албан тушаалтны гэм буруутай эсэхийг нь огт харгалзаж үзэхээргүй байна. Гэтэл гэм буруутай эсэхийг нь тогтоохгүйгээр гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхгүй тухай Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14-т “Гэм

<sup>13</sup> Д.Баярсайхан, Эрх зүйн онол, (Уб, 2023), 50 дахь тал.

буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.” гэж заасан байна. Мөн Эрүүгийн хуульд 1.4 дүгээр зүйлийн 1-д “Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.” гэж гэм буруугийн зарчмыг тодорхойлсон байна. Эндээс гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхийн тулд шүүхээс заавал гэм буруутайг нь тогтоох ёстой бөгөөд гэм буруутай хүнд л хариуцлага оногдуулах ёстой хэмээн ойлгогдож байна.

Нийтийн албан тушаалтны хөрөнгийг хураах гол үндэслэл нь тухайн хөрөнгийн хууль бус шинж байх тухай хуулийн төслийн санаачлагч хуулийн төслийн үзэл баримтлалд дурдаж, хуулийн төслийн холбогдох зохицуулалтуудаас ч энэ нь тодорхой харагдаж байна. Хууль бус буюу *illegal* шинж нь гэм буруу болоод хууль зөрчих ойлголттой зайлшгүй холбогдох бөгөөд ялгаж, тусгаарлаж авч үзэх нь өрөөсгөл. Хөрөнгийн хууль бус шинжийг гэмт хэрэг гэж үзэхгүй байх буюу “авлига” үйлдэхийг гэм буруутай үйлдэл биш гэж үзэх логик боломжийг бий болгосон байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан зохицуулалт нь хэрэгжиж эхэлбэл гэм буруугүй ч хөрөнгөө хураалгах нь хүний эрхийн зөрчил үүсгэх эсэх, эсвэл авлига авах нь гэм буруутай үйлдэл биш хэмээн үзэх эсэх тухай манай улсын эрх зүйн тогтолцоонд *парадокс* үүсгэж болох юм. Түүнчлэн, нийтийн албан тушаалтан гэх субъектийг иргэн буюу хүн гэдэг ойлголтод хамааруулахгүй байх нь зөвхөн ялгаварлан гадуурхахаас илүү үр дагаврыг (өмчлөх эрхийг үгүйсгэх гэх мэт) эрх зүйн тогтолцоонд учруулж болохыг дурдах нь зүйтэй.

**Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.4-т** “Нийтийн албан тушаалтны холбогдсон гэмт хэргийг эрүүгийн журмаар хянан шийдвэрлэхдээ гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураалгүйгээр шийдвэрлэсэн нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нехөн төлүүлэх ажиллагааг явуулах үндэслэл болно.” Монгол Улсад гэмт хэргийг хянан шийдвэрлэх эрх гагцхүү шүүхэд бий. Гэтэл дээрх зохицуулалтаас үзвэл шүүх тухайн хөрөнгө, орлогыг хураах тухай шийдвэрлээгүй нь тэрхүү хөрөнгийг хураан авах үндэслэл болно гэж ойлгогдож байна. Шүүхийн шийдвэрлээгүй байгаа нь тодорхой процесс явагдах буюу эхлэх хууль зүйн үндэслэл болох буюу тухайн хэрэгжих процесс нь өмчлөх эрхэд халдаж буй процесс байгаа нь үндсэн хуулийн эрх зүйн зөрчлийг үүсгэх эрсдэлтэй байж болох юм. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1-д “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж, мөн зүйлийн 2-т “Ямар ч нехцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.” гэж тус тус заасанд нийцэхгүй байна.

Мөн шүүхийн шийдвэрийн дараа бие даасан процесс ажиллагаа хэрэгжих нь тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр эцсийнх биш болохыг харуулж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2-т “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ.” хэмээн заасныг үгүйсгэж байна.

**Эцэст нь тус хуулийн төслийн 5 дугаар зүйл шударга ёсны зарчим болж чадах уу? гэдэгт хариулт өгөх шаардлагатай болж байна.** Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт шударга ёсыг эрхэмлэн дээдлэхийг зорилго хэмээн тунхаглаж, Нэгдүгээр зүйлийн 2-т “Ардчилсан ёс, *шударга ёс*, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасан. Үүнийг доктор, профессор Н.Лүндэндорж “Доктор Найжел Ашфорд *шударга ёс* бол хууль дүрэм хэрхэн мөрдөгдөж байгаагаар илэрнэ хэмээн тэмдэглэснийг Монгол

Улсын Үндсэн хууль төр ёсны гол зарчим, зорилго болгосон байна.”<sup>14</sup> хэмээн тайлбарласан. Мөн доктор, профессор Д.Баярсайхан *шударга ёсыг* хүний эрх, эрх чөлөөтэй салшгүй холбоотой, жам ёсны эрх зүйн чухал үнэт зүйл бөгөөд тэгш эрх ба тэгш бус эрхийн харилцан нөхцөлдсөн зүй тогтолт байдлын зохилдоо болж оршдог<sup>15</sup> хэмээн үзсэн байна. Иймд Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хуульд нийцэхгүй, эрх зүйн тогтолцоонд парадокс үүсгэж болзошгүй үр дагавар бүхий тус хуулийн төслийн 5 дугаар зүйлийг шударга ёсны зарчим хэмээн үзэх боломжгүй байна.

### 3.3. Хууль бус хөрөнгө шалгах, хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогчийн тухай зохицуулсан тус хуулийн 7-17 дугаар зүйл

#### 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт “Хууль бус хөрөнгө шалгах, хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогч”-ийг тусгасан бөгөөд хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1-д “...Энэ хуулийн 3.1-д заасан хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газар, цагдаа, тагнуулын байгууллага дахь тусгайлсан нэгжийн мөрдөгч хэрэгжүүлнэ...” гэж мөн зүйлийн 7.2-т “...Энэ хуулийн 3.2-т заасан ажиллагааг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газрын мөрдөгч хэрэгжүүлнэ...” гэж тус тус зохицуулжээ. Дээрх зохицуулалтаас үзвэл, хууль бус хөрөнгийг хураан авах ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагад шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газар, цагдаа, тагнуул гэсэн 5 байгууллага хамаарч байна.

Харин хууль бус хөрөнгө шалгах, хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаанд оролцогчид хэнийг хамаарулахаа тодорхой байдлаар хуулийн төсөлд нарийвчлан тусгаагүй байна. Тус бүлгийн 7 дугаар зүйлд заасан “Хууль бус хөрөнгө шалгах, хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогч”-оос бусад зохицуулалтыг “оролцогч” гэж үзэх нь учир дутагдалтай. Тус бүлэгт:

- 8 дугаар зүйл. Шүүх
- 9 дүгээр зүйл. Прокурор
- 10 дугаар зүйл. Мөрдөгч
- 11 дүгээр зүйл. Өмгөөлөгч
- 12 дугаар зүйл. Холбогдолч
- 13 дугаар зүйл. Гэрч
- 14 дүгээр зүйл. Иргэний нэхэмжлэгч
- 15 дугаар зүйл. Шинжээч
- 16 дугаар зүйл. Мэргэжилтэн
- 17 дугаар зүйл. Орчуулагч, хэлмэрчийг тус тус тусгажээ.

Хуулийн төслийн 4.1.17-д “...“шалгах ажиллагааны оролцогч” гэж холбогдолч нийтийн албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд, гуравдагч этгээд, гэрч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, мэргэжилтнийг...” хамааруулан зохицуулжээ. Энэ нь хуулийн төслийн 2 дугаар бүлэгт заасан дээрх зохицуулалтаас ялгамжтай байна. Тухайлбал, холбогдолч нийтийн албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд, өмгөөлөгч хэргийн оролцогч мөн эсэх, хуулийн төслийн 12 дугаар зүйлд “холбогдолч”

<sup>14</sup> Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар, (Уб, 2022), 29 дэх тал.

<sup>15</sup> Д.Баярсайхан, Эрх зүйн онол, (Уб, 2023), 25 дахь тал.

гэх Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан нэр томьёог тусгаж, төслийн мөн зүйлийн 12.4-т "...холбогдогчийг шүүхийн шатанд зохигч буюу хариуцагч гэх..." гэж, мөн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д "... холбогдогч нийтийн албан тушаалтан..." гэж иргэн, зөрчил, эрүүгийн нэр томьёог өөр хооронд нь хольж тусгасан нь тус зохицуулалтын зорилгод хүрэх байдлыг алдагдуулж байна.

Нөгөөтээгүүр, ЭХХШТХ, ИХШХШТХ-д хэргийн оролцогч, бусад оролцогч зэргийг хуулийн төслийн дээрх зохицуулалтаас ялгаатай байдлаар зохицуулсныг дурдах нь зүйтэй. Иймд хуулийн төсөлд "оролцогч"-ийг тодорхой байдлаар тусгах нь зүйтэй.

## 2. "Практикт хэрэгжих байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах ажиллагааг хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газар, цагдаа, тагнуулын байгууллага дахь тусгайлсан нэгжийн мөрдөгч хэрэгжүүлэхээр тусгажээ.

Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.1.2.6 дэд заалтад "Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд хамрагдсан" бол хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа явуулахаар зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, дээрх эрх бүхий 5 байгууллагын тусгайлсан нэгжийн мөрдөгч шалгах ажиллагаа явуулсны үндсэн дээр нотлох баримт цуглуулж, хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаа явуулахаар зохицуулжээ.

Харин Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Энэ хуулийн 4.1, 5.1-д заасны дагуу хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх хувь хүн, хуулийн этгээдэд ийнхүү чөлөөлөгдөхөөр заасан үндэслэлээр дахин эрүүгийн хэрэг үүсгэх, захиргааны хариуцлага хүлээлгэх, гүйцэтгэх ажиллагаа явуулахыг хориглоно." гэж заасан. Энэхүү зохицуулалтад заасан үндэслэлээр хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх хувь хүн, хуулийн этгээдэд ийнхүү чөлөөлөгдөхөөр заасан үндэслэлээр "гүйцэтгэх ажиллагаа явуулахыг хориглосон" байна.

Өөрөөр хэлбэл, ЭЗИТБДТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг заасан дараах үндэслэл хуулийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэлд хамаарч байна.

### 4 дүгээр зүйл. Бүртгүүлэх, мэдүүлэх, тайлагнах ажиллагаа

4.1. Татварын болон Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хүрээнд 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх хугацаанд тухайн төрлийн албан татвар төлөгчөөр татварын албанад, ажил олгогчоор нийгмийн даатгалд, эд хөрөнгө, үйл ажиллагаагаа улсын бүртгэлд бүртгүүлсэн, санхүү, татварын тайлангаа гаргасан байвал зохих хувь хүн, хуулийн этгээд ийнхүү бүртгүүлээгүй, мэдүүлээгүй, тайлагнаагүй боловч энэ хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагад сайн дурын үндсэн дээр шинээр бүртгүүлсэн, мэдүүлсэн, тайлагнасан бол, мөн холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө, орлогоо бүртгүүлээгүй, мэдүүлээгүй хувь хүн, хуулийн этгээд энэ хуулийн хэрэгжих хугацаа дуусгавар болохоос өмнө холбогдох байгууллагад сайн дурын үндсэн дээр шинээр бүртгүүлсэн, мэдүүлсэн бол доор дурдсан хуульд заасан бүртгэлд хамрагдаагүй, албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй, хөрөнгө, орлогоо нуун дарагдуулсны улмаас хүлээх хариуцлагаас нэг удаа чөлөөлнэ:

/Энэ хэсэгт 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

4.1.1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;

4.1.2. Татварын ерөнхий хууль;

4.1.3. Нийгмийн даатгалын ерөнхий хууль;

/Энэ заалтад 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

4.1.4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль;

4.1.5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;

4.1.6. Гаалийн тухай хууль;

#### 4.1.7. Захиргааны хариуцлагын тухай хууль.

**5 дугаар зүйл. Албан татвар ногдох орлого, орлогоос бусад албан татвар ногдох зүйлийг мэдүүлэх, нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогыг тайлагнах**

5.1. Албан татвар ногдох орлого, орлогоос бусад албан татвар ногдох зүйл, нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогыг 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх хугацаанд нуун дарагдуулсан боловч энэ хуулийн 3.1-д заасан хугацаанд сайн дурын үндсэн дээр ил болгож, санхүүгийн болон албан татварын, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг шинээр гаргаж харьялах татварын алба, нийгмийн даатгалын байгууллагад сайн дурын үндсэн дээр мэдүүлсэн бол тухайн хувь хүн, хуулийн этгээдийг энэ хуулийн 4.1-д заасан хуульд заасан хариуцлагаас нэг удаа чөлөөлнө.

Гэтэл Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д “**тагнуулын байгууллага** нь гадаад тагнуул, хилийн тагнуул, сөрөх тагнуулын чиглэлээр гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий бусад мэдээ олох, дэмжлэг үзүүлэх, үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй гадаад, дотоод эрсдэл, аюул, занал, хуулиар харьялуулсан гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох;” гэж, мөн зүйлийн 9.1.3-т “**цагдаагийн байгууллага** энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас бусад далд аргаар үйлдэгдсэн, эсхүл тодорхой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох, олон нийтийн аюулгүй байдал болон шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, түүнчлэн сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон прокурор, шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох;”, мөн зүйлийн 9.1.6-д “**Авлигатай тэмцэх газар** нь авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гэм буруутай этгээдийг олж тогтоох, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах” гэж тус тус заажээ.

Дээрх зохицуулалтаас харвал, Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.3, 9.1.6-д заасны дагуу Тагнуулын байгууллага, Цагдаагийн байгууллага болон Авлигатай тэмцэх газар хуульд заасан үндэслэлээр гүйцэтгэх ажиллагаа явуулахаар заажээ.

Харин хуулийн төслийн 28.1.2.6 дэд заалтад “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд хамрагдсан” бол хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа явуулахаар тусгасан боловч ЭЗИТБДтХ-д 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөхөөр заасан бол хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх, шалгах ажиллагаа явуулахдаа гүйцэтгэх ажил явуулж болохгүй байна.

Иймд хуулийн төслийн 28.1.2.6 дэд заалтад “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд хамрагдсан” тохиолдолд хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа явуулах зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхдээ дээрх асуудлыг харгалзан үзэх нь зүйтэй.

#### 3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн 7-17 дугаар зүйл буюу 3 дугаар бүлэгт хууль бус хөрөнгө шалгах, хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогчийн тухай зохицуулсан бөгөөд хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан

хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газар, цагдаа, тагнуулын байгууллага дахь **тусгайлсан нэгжийн мөрдөгч хэрэгжүүлнэ.**" гэж заажээ. Ийнхүү зохицуулсан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчидтэй адил байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хоёрдугаар хэсэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогчийн тухай зохицуулсан байдаг. Үүнд:

- Шүүх
- Прокурор
- Өмгөөлөгч
- **Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан**
- Яллагдагч
- Хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч
- Бусад оролцогч багтдаг байна.

Эрүүгийн процессын бүхий л ажиллагаанд эрх, үүрэг нь харилцан адилгүй олон төрлийн субъект оролцдог учир тодорхой эрх зүйн шалгуураар ангилан авч үздэг. Эрүүгийн процессын эрх зүйд Эрүүгийн процессын хэрэгжүүлэгч субъект гэж дараах субъектүүдийг ойлгодог. Тэдгээр нь:

- **Мөрдөгч**
- **Мөрдөн шалгах байгууллага**
- **Мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга**
- Прокурор
- Шүүх, шүүгч болно.<sup>16</sup>

Энэхүү хэрэгжүүлэгч субъектүүд нь Эрүүгийн процессын явцад хүний эрхийг хязгаарлахад чиглэгдсэн ажиллагааг явуулж, нотлох баримт цуглуулж бэхжүүлэх, шалгаж үнэлэх эрхтэй байдаг онцлогтой. Иймд хуулийн төсөл дэх хэрэгжүүлэгчид болоод оролцогчдыг нэг бүрчлэн авч үзье.

## Прокурор

Манай улсад шүүхийн процесс дахь прокурорын оролцоо маш тодорхой байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1-д "Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно" заасан. Энэ нь прокурор эрүүгийн хэрэгт хяналт тавьж шүүхэд яллах байр сууринаас оролцох эсвэл иргэн болон захиргааны шүүхэд төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар нэхэмжлэгчийн байр сууринаас оролцох тухай агуулга юм. Мөн эрүүгийн хэрэгт прокурор шүүхийн шатанд зөвхөн улсын яллагч байх бол иргэн болон захиргааны хэрэгт зөвхөн нэхэмжлэгч тал байх тухай юм. Гэтэл хуулийн төсөлд прокурор шүүхийн өмнөх шатанд эрүүгийн хэрэгт хяналт тавьж буй мэт, харин шүүхийн шатанд нэхэмжлэгч байхаар зохицуулжээ.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Прокурорын тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэж заасан нь прокурор хөрөнгө хураах ажиллагаанд ЭХХШТХ-ийн 4.1 дүгээр зүйлийн 1-д "Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцоно." гэж заасан процесс ажиллагааг бүхэлд нь хянах, шүүх

<sup>16</sup> Д.Баярсайхан, Эрүүгийн процессын эрх зүй, (Уб, 2020), 110 дахь тал.

хуралдаанд улсын яллагчаар оролцох бүрэн эрхийг шууд эдлэх тухай агуулгатай байна. Гэтэл хуулийн төслийн 9.2-т “Прокурорыг шүүхийн шатанд зохигч буюу нэхэмжлэгч гэх бөгөөд шүүхийн шатанд прокурор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 26 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.” гэж заасан нь юун түрүүнд заалт хооронд уялдаа холбоог алдагдуулсан байна. Мөн “Прокурорыг шүүхийн шатанд зохигч буюу нэхэмжлэгч гэх” гэж зааснаар тухайн процесс ажиллагаанд прокурор шууд нэхэмжлэгч болохгүй. Шүүхээс өмнөх шатанд нэхэмжлэгчийн байр сууринаас хөрөнгө хураах ажиллагаанд оролцоогүй атал шүүхийн шат эхлэхэд шууд зохигч буюу нэхэмжлэгчийн эрх эдэлж, үүрэг хүлээх нь эрх зүйн онол, тэр дундаа иргэний процесс эрх зүйн үүднээс “байж үл болох” зүйл бөгөөд үүний үр дагавар зөвхөн онолын зөрчилдөөнөөр хязгаарлагдахгүй эрх зүйн тогтолцоо, үндсэн хуулийн зөрчилд хүрэх эрсдэлтэй байж болохыг сануулах нь зүйтэй.

## Мөрдөгч

Хуулийн төслийн 10 дугаар зүйлд мөрдөгчийн тухай зохицуулсан байна. Тус зүйлийн 10.1-д “Хөрөнгө шалгах ажиллагааг эрх бүхий мөрдөгч (цаашид “мөрдөгч” гэх) явуулна.” гэж заагаад мөрдөгчийн эрхийг тоочих байдлаар заасан байх ба үүнийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай харьцуулан авч үзэв. Мөн тус зүйлийн 10.3-т “Мөрдөгч шалгах ажиллагааны явцад Цагдаагийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэж болно.” гэж заасан байна. Эдгээр зохицуулалтаас хөрөнгө шалгах ажиллагаанд албадлага хэрэглэх эрхтэй мөрдөгч хэрэгжүүлэгч субъектийн хувиар оролцох болох нь тодорхой байна.

### Хүснэгт 7. Хөрөнгө хураах ажиллагааны мөрдөгчийн бүрэн эрхийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай харьцуулсан нь

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
<p><b>10 дугаар зүйл.Мөрдөгч</b></p> <p>10.1.Хөрөнгө шалгах ажиллагааг эрх бүхий мөрдөгч (цаашид “мөрдөгч” гэх) явуулна. Хөрөнгө шалгах ажиллагаа явуулах мөрдөгч нь дараах эрхтэй:</p> <p>10.1.1.шалгах ажиллагаа явуулах хэрэг нээх;</p> <p>10.1.2.хөрөнгө шалгах тодорхой төрлийн ажиллагаа явуулах санал прокурорт гаргах;</p> <p>10.1.3.прокурорын зөвшөөрөл авахаар хуульд зааснаас бусад тохиолдолд хууль бус хөрөнгийг нотлох ажиллагааг бие даан явуулах;</p> <p>10.1.4.шалгах ажиллагаанд ач холбогдол бүхий этгээдийг дуудан ирүүлэх;</p> <p>10.1.5.шинжилгээ хийлгэхээр шинжээч томилох;</p> <p>10.1.6.оролцогчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх;</p> <p>10.1.7.шалгах ажиллагааны хэргийг хаасан прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл 5 хоногийн дотор дээд шатны прокурорт бичгээр санал</p>	<p><b>6.2 дугаар зүйл.Мөрдөгч</b></p> <p>1.Мөрдөгч... эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулна.</p> <p>2.Мөрдөгч дараах эрхтэй:</p> <p>2.1.хэрэг бүртгэлтийн хэрэг нээх;</p> <p>2.2.эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах санал прокурорт гаргах;</p> <p>2.4.хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд прокурорын зөвшөөрлөөр явуулах мөрдөн шалгах ажиллагааг явуулах саналыг прокурорт гаргах;</p> <p>2.5.прокурорын зөвшөөрөл авахаар хуульд зааснаас бусад тохиолдолд гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, олж тогтоох мөрдөн шалгах ажиллагааг бие даан явуулах;</p> <p>2.6.гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагчийг дуудан ирүүлэх;</p> <p>2.7.шинжилгээ хийлгэхээр шинжээч томилох;</p> <p>2.10.оролцогчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх;</p> <p>2.12.хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл 5</p>

<p>гаргах;</p> <p>10.1.8.прокурорын зөвшөөрлөөр мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулахаар эрх бүхий байгууллагад даалгавар бичиж, гүйцэтгүүлэх;</p> <p>10.1.9.өөр нутаг дэвсгэрт шалгах ажиллагаа явуулах шаардлага гарвал энэ тухай даалгаврыг бичгээр хүргүүлэх ба түүнийг хүлээн авсан эрх бүхий байгууллага даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамтаар ирүүлэх;</p> <p>10.1.10.энэ хуульд заасан бусад эрх.</p> <p>10.2.Мөрдөгч нийтийн албан тушаалтны хөрөнгийн эх үүсвэрийг тогтоох талаар энэ хуульд заасан ажиллагаа явуулна.</p> <p>10.3.Мөрдөгч шалгах ажиллагааны явцад Цагдаагийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэж болно.</p>	<p>хоногийн дотор дээд шатны прокурорт бичгээр санал гаргах;</p> <p>2.13.прокурорын зөвшөөрлөөр мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулахаар эрх бүхий байгууллагад даалгавар бичиж, гүйцэтгүүлэх;</p> <p>2.14.өөр нутаг дэвсгэрт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрэн сурвалжлах шаардлага гарвал энэ тухай даалгаврыг бичгээр хүргүүлэх ба түүнийг хүлээн авсан мөрдөн шалгах байгууллага даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамтаар ирүүлэх;</p> <p>2.15.энэ хуульд заасан бусад эрх.</p> <p><b>4.Мөрдөгч гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох талаар энэ хуульд заасан ажиллагаа явуулна.</b></p> <p><b>7.Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэж болно.</b></p>
---	---

Дээрх хүснэгтээс харвал, хуулийн төсөлд мөрдөгчийн эрхийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай адил зохицуулсан болох нь харагдаж байна. Эндээс мөрдөгч албадлага хэрэглэх эрхтэй байх нь хөрөнгө хураах ажиллагаанд зохимжтой эсэх буюу хуульд нийцэх эсэх тухайд тухайллан авч үзье.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай нэгэн адил тодорхойлогдсон тус албадлагыг Эрүүгийн процесс дахь албадлага хэмээн үзэх нь үндэслэлтэй. Эрүүгийн процесс дахь албадлага нь хүний эрхийг хязгаарлах шууд үр дагавартай байдгийн хувьд онцгой шаардлагыг урьдаар заавал хангасан байхыг шаарддаг. Хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хэрэгжүүлдэг онцгой арга хэмжээ учир зөвхөн эрүүгийн хэрэг үүсгэсэн тохиолдолд хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд л хэрэглэдэг.<sup>17</sup> Мөн зөвхөн хуульд заасан зарчим, журмын дагуу тодорхой процедурын дагуу хэрэгждэг. Гэтэл хуулийн төсөлд албадлага хэрэглэх зарчим болоод зорилго үндэслэл ч байхгүй. Эрүүгийн процесст албадлагыг тус ажиллагааг саадгүй явуулахын тулд, эсвэл хамгаалалтын зорилгоор ашигладаг бол хөрөнгө хураахад ямар зорилго, үндэслэлээр албадлага хэрэглэх шаардлага байгаа нь ойлгомжгүй буюу огт тодорхойгүй байна. Монгол Улс бол эх газрын эрх зүйн тогтолцоотой орны хувьд (цаашид ч уг тогтолцоог хөгжүүлэхээр ХЗДХЯ-аас Эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэхээр ажиллаж байгаа билээ) Эрүүгийн болон эрүүгийн процессын албадлага хэрэглэх ажиллагаанд хуулийн төсөөтэй хэрэглэх явдлыг Эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудын хувьд хориглодгийг санах нь зүйтэй.<sup>18</sup>

Эрүүгийн процессыг хэрэгжүүлэгч буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъекттэй адил байх бөгөөд үүгээр зогсохгүй тэдгээрийн эрх, үүргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасантай мөн адил байхаар заажээ. Гэтэл хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1-д шүүхийн тухай заахдаа “шүүх нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн

<sup>17</sup> Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй Ерөнхий анги, (Уб, 2004).

<sup>18</sup> Д.Баярсайхан, Эрүүгийн процессын эрх зүй, (Уб, 2020), 151 дахь тал.

төлүүлэх ажиллагааг хянан шийдвэрлэхдээ энэ хууль болон *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтлан явуулна*." гэжээ. Эндээс хууль бус хөрөнгө шалгах, хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаанд шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэх буюу иргэний процессын эрх зүйн зохицуулалтыг хэрэглэн шийдвэр гаргах ёстой ажээ. Түүнчлэн, Хууль бус хөрөнгө шалгах, хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаа нь шүүхийн өмнөх болон шүүхийн шат гэх үндсэн хоёр үе шатанд хуваагдаж байгааг харж болохоор байна.

Дээрхээс нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааны хэрэгжүүлэгч нь эрүүгийн процесс ажиллагааны хэрэгжүүлэгчтэй төсөөтэй хэмээн дүгнэж болохоор байна. Тэгвэл бусад оролцогч нарын тухайд хэрхэн зохицуулсныг авч үзье.

**Хүснэгт 8. Хөрөнгө хураах ажиллагааны оролцогчийн эрх, үүргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай харьцуулсан нь**

№	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
1.	<p>11 дүгээр зүйл. Өмгөөлөгч</p> <p>11.1. ...өмгөөлөгч дараах эрхтэй:</p> <p>11.1.1. нийтийн албан тушаалтантай <b>ганцаарчлан уулзах</b>, түүнээс тайлбар авахад <b>байлцах, асуулт тавих</b>;</p> <p>11.1.2. хөрөнгө шалгах ажиллагааны явцад <b>шинжээчээс мэдүүлэг авахуулахаар хүсэлт гаргах</b>;</p> <p>11.1.3. хөрөнгө шалгах ажиллагааны явцад <b>шинжээчийн дүгнэлттэй танилцах, өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах, нэмэлт ба дахин шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах</b>;</p> <p>11.1.4. хууль зүйн туслалцаа үзүүлэхэд <b>шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурорт гаргаж өгөх, түүнийг хэрэгт бэхжүүлж тусгуулах, хөрөнгө шалгах ажиллагааны явцад тодорхой төрлийн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах</b>;</p> <p>11.1.5. өмгөөлж байгаа нийтийн албан тушаалтны <b>хүсэлтээр хийгдэж байгаа хөрөнгө шалгах ажиллагаанд байлцаж, асуулт тавих, хүсэлт гаргах</b>;</p> <p>11.1.6. өөрийн оролцсон хөрөнгө шалгах ажиллагаа, <b>шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах тухай хүсэлт гаргах</b>;</p> <p>11.1.7. хөрөнгө шалгах ажиллагааны явцад <b>өөрсдийнх нь зөвшөөрснөөр хүн, хуулийн этгээдээс хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт бичиг, лавлаганаа, тодорхойлж гаргуулж авах</b>;</p> <p>11.1.8. мөрдөгч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах хүсэлт гаргах;</p> <p>11.1.9. хөрөнгө шалгах ажиллагааны <b>хэргийг хаасан, эсхүл хөрөнгө хураах,</b></p>	<p>5.1 дүгээр зүйл. Өмгөөлөгчийн эрх, үүргэг</p> <p>2.Өмгөөлөгч дараах эрхтэй:</p> <p>2.1.гэрч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй <b>ганцаарчлан даруй уулзах, түүнээс мэдуулэг авахад байлцах, асуулт тавих</b>;</p> <p>2.2.хохирогч, гэрч, <b>шинжээчээс мэдүүлэг авахуулахаар хүсэлт гаргах</b>;</p> <p>2.3.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад <b>шинжээчийн дүгнэлттэй танилцах, өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах, нэмэлт ба дахин шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах</b>;</p> <p>2.4.хууль зүйн туслалцаа үзүүлэхэд <b>шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурорт гаргаж өгөх, түүнийг хавастст хэрэгт бэхжүүлж тусгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах</b>, энэ хуульд заасан журмын дагуу оролцох;</p> <p>2.5.<b>өмгөөлж байгаа сэжигтэн, хохирогч, яллагдагч, шүүгдэгч, ялтны, эсхүл өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд байлцаж, аль ч үед асуулт тавих, хүсэлт гаргах</b>;</p> <p>2.6.<b>өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах тухай хүсэлт гаргах</b>;</p> <p>2.7.<b>өөрсдийнх нь зөвшөөрснөөр хүн, хуулийн этгээдээс хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт</b></p>

	<p>нөхөн төлүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэргийн материалтай танилцаж, төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах;</p> <p>11.1.10. шүүхийн хуралдаанд оролцох;</p> <p>11.1.11. мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүхийн ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;</p> <p>11.1.12. анхан, давж заалдах, хяналтын шатны шүүх хуралдаанд оролцох;</p> <p>11.1.13. хөрөнгө хураан авах ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж оролцогчид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх санал гаргах;</p> <p>11.1.14. энэ хуульд заасан бусад эрх;</p> <p>11.2. Өмгөөлөгч нь шүүх, прокурор, мөрдөгчийн товлосон хугацаанд хүрэлцэн ирж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно. Хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцох боломжгүй бол энэ тухай урьдчилж мэдэгдэнэ.</p> <p>11.3. Өмгөөлөгч тухайн нийтийн албан тушаалтны өмгөөлөгчөөр оролцох болсноо үйлчлүүлэгчийн бичгээр үйлдсэн хүсэлтээр баталгаажуулж, шүүх, прокурор, мөрдөгчид бичгээр мэдэгдэнэ.</p> <p>11.4. Өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээгээр хүлээсэн өмгөөлөх, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээсээ татгалзаж болохгүй.</p>	<p>бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулж авах;</p> <p>2.8. мөрдөгч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах хүсэлт гаргах;</p> <p>2.9. хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хэргийн бүх материалтай танилцаж, төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах;</p> <p>2.10. шүүхийн хэлэлцүүлэгт оролцох;</p> <p>2.11. мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүхийн ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;</p> <p>2.13. анхан, давж заалдах, хяналтын шатны шүүх хуралдаанд оролцох;</p> <p>2.14. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж оролцогчид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх санал гаргах;</p> <p>2.15. энэ хуульд заасан бусад эрх.</p> <p>3. Өмгөөлөгч нь шүүх, прокурор, мөрдөгчийн товлосон хугацаанд хүрэлцэн ирж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно. Хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцох боломжгүй бол энэ тухай урьдчилж мэдэгдэнэ.</p> <p>4. Өмгөөлөгч тухайн хүн, хуулийн этгээдийн өмгөөлөгчөөр оролцох болсноо үйлчлүүлэгчийн бичгээр үйлдсэн хүсэлтээр баталгаажуулж, шүүх, прокурор, мөрдөгчид бичгээр мэдэгдэнэ.</p> <p>5. Өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээгээр хүлээсэн өмгөөлөх, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээсээ татгалзаж болохгүй.</p>
2.	<p>13 дугаар зүйл. Гэрч</p> <p>13.1. Хөрөнгө шалгах ажиллагаанд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ.</p> <p>13.2. Гэрч шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирж, хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн зөв</p>	<p>9.6 дугаар зүйл. Гэрч</p> <p>1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ.</p> <p>2. Гэрч шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирж, хэргийн талаар өөрийн</p>

	<p>мэдүүлэх үүрэгтэй.</p> <p>13.3. Гэрч дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг шүүхийн шийдвэрээр албадан ирүүлнэ.</p> <p>13.4. Гэрч хөрөнгө шалгах ажиллагаанд саад учруулсан, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Зөрчлийн хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>13.5. Аюулгүй байдлаа хангуулах талаарх хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргана.</p> <p>13.6. Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй.</p> <p>13.7. Мэдүүлэг авахаас өмнө энэ хуульд заасан гэрчийн эрх, үүргийг тайлбарлаж өгнө.</p>	<p>мэдэх зүйлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.</p> <p>3.Гэрч дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг шүүхийн шийдвэрээр албадан ирүүлнэ.</p> <p>4.Гэрч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>5.Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй.</p> <p>8.Шүүх, прокурор, мөрдөгч мэдүүлэг авахаас өмнө гэрчид энэ хуульд заасан гэрчийн эрх, үүргийг тайлбарлаж өгнө.</p>
3.	<p><b>14 дүгээр зүйл. Иргэний нэхэмжлэгч</b></p> <p>14.1.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хууль бус болохыг мэдээгүй, мэдэх боломжгүйгээр хууль ёсны дагуу хийсэн хэлцлийн үндсэн дээр эд хөрөнгийн хохирол учирсан хүн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ.</p> <p>14.2.Иргэний нэхэмжлэгч нь холбогдогч нийтийн албан тушаалтнаас өөрт учирсан хохирлыг гаргуулахаар иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тус нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ.</p> <p>14.3.Мөрдөгч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргаж иргэний нэхэмжлэгчээр тогтооно.</p> <p>14.4.Хөрөнгө хураан авах ажиллагааны явцад гаргасан иргэний нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгднө.</p> <p>14.5.Иргэний нэхэмжлэгчид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.4, 1.5, 1.6, 1.8, 1.10, 1.11-т заасан эрх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 26, 27 дугаар заасан эрх, үүрэг нэгэн адил хамаарна.</p> <p>14.6.Учирсан хохиролтой холбогдолтой нэхэмжлэлийг тухайн хөрөнгө хураан авах ажиллагаа шийдвэрлэгдээгүй байхад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхийг хориглоно.</p> <p>14.7.Иргэний нэхэмжлэгч нь шүүхийн шийдвэрийн зөвхөн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргаж болно.</p> <p>14.8.Энэ хуулийн 14.2-т заасан үндэслэл байхгүй бол нэхэмжлэл гаргасан хүн, хуулийн этгээдийн нэхэмжлэлийг хүлээн</p>	<p><b>8.5 дугаар зүйл. Иргэний нэхэмжлэгч</b></p> <p>1.Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа хүн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ.</p> <p>2.Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ.</p> <p>3.Мөрдөгч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргаж иргэний нэхэмжлэгчээр тогтооно.</p> <p>4.Эрүүгийн хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгднө.</p> <p>5.Иргэний нэхэмжлэгчид энэ хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.4, 1.5, 1.6, 1.8, 1.10, 1.11-д заасан эрх болон энэ бүлэгт заасан үүрэг нэгэн адил хамаарна.</p> <p>6.Гэмт хэргийн улмаас учирсан хохиролтой холбогдолтой нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байхад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхийг хориглоно.</p> <p>7.Иргэний нэхэмжлэгч нь шүүхийн тогтоол, магадлалын зөвхөн иргэний</p>

	<p>авах, иргэний нэхэмжлэгчээр тогтоохоос үндэслэл бүхий шийдвэр гарган татгалзаж болох ба энэхүү шийдвэрт гомдол гаргах журмыг нэхэмжлэл гаргагчид тайлбарлана.</p> <p>14.9.Хөрөнгө шалгах ажиллагааны явцад нэхэмжлэгчээр тогтоохоос татгалзсан нь шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх шатанд тухайн асуудлаар дахин нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.</p> <p>14.10.Иргэний нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээс татгалзах эрхтэй. Нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг мөрдөгч, прокурор хөрөнгө хураан авах ажиллагааны аль ч үед хүлээн авах ба энэ тухай тогтоол гаргана.</p> <p>14.11.Нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг хөрөнгө хураан авах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэлд тусгах ба хэрэв бичгээр гаргасан бол хэрэгт хавсаргана.</p>	<p>нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргаж болно.</p> <p>8.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэл байхгүй бол нэхэмжлэл гаргасан хүн, хуулийн этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авах, иргэний нэхэмжлэгчээр тогтоохоос үндэслэл бүхий шийдвэр гарган татгалзаж болох ба энэхүү шийдвэрт гомдол гаргах журмыг нэхэмжлэл гаргагчид тайлбарлана.</p> <p>9.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нэхэмжлэгчээр тогтоохоос татгалзсан нь шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх шатанд тухайн асуудлаар дахин нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.</p> <p>10.Иргэний нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээс татгалзах эрхтэй.</p> <p>11.Нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон шүүх хуралдааны тэмдэглэлд тусгах ба хэрэв бичгээр гаргасан бол хавастст хэрэгт хавсаргана.</p> <p>12.Нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг мөрдөгч, прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед хүлээн авах ба энэ тухай тогтоол гаргана.</p> <p>13.Шүүхэд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх үед нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг шүүх зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө гаргаж болох ба хүсэлтийг шүүх хангана.</p> <p>14.Нэхэмжлэлээс татгалзсан нь хууль зөрчсөн, эсхүл аль нэг этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохиросон гэж үзвэл мөрдөгч, прокурор, шүүх нь түүний хүсэлтийг хүлээн авахгүй байж болох ба энэ тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.</p>
4.	<p><b>15 дугаар зүйл. Шинжээч</b></p> <p>15.1. Шинжээч нь Шүүх шинжилгээний тухай хуулийн 49.1-д заасан эрхээс гадна дараах эрхийг эдэлнэ:</p> <p>15.1.1. прокурор, мөрдөгчийн зөвшөөрснөөр шинжилгээ хийхтэй холбоотой асуудлаар оролцогчид асуулт тавих, тодруулга хийх</p> <p>15.1.2. дүгнэлт гаргахад хэрэгцээтэй нэмэлт баримт ирүүлэх талаар прокурор, мөрдөгчид хандаж хүсэлт гаргах</p> <p>15.1.3. өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангуулах талаарх хүсэлтийг шүүх,</p>	<p><b>9.1 дүгээр зүйл. Шинжээч</b></p> <p>1.Прокурор, мөрдөгч нь өөрийн санаачилгаар, эсхүл оролцогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах асуудлыг тодруулахаар, эсхүл эд зүйл, хөрөнгийн үнэлгээ, хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, сэтгэцэд учирсан хор уршигийн зэрэглэлийг тогтоолгохоор шинжилгээ</p>

	<p>прокурор, мөрдөгчид гаргах.</p> <p>15.2. Шинжээч нь прокурор, мөрдөгчийн тавьсан асуултын дагуу <b>тусгай мэдлэг</b>, мэргэжлийн хүрээнд шинжилгээг тал бүрээс нь бүрэн бодитой хийж, тогтоосон хугацаанд шинжлэх ухааны үндэслэл бүхий дүгнэлтийг бичгээр гаргана.</p> <p>15.3. Дүгнэлт гаргасан шинжээч нь мэдүүлэг авахаар шүүх, прокуророос дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг хуульд заасны шүүхийн шийдвэрээр албадан ирүүлнэ.</p> <p>15.4. Шинжээч нь хараат бусаар, үнэн зөв дүгнэлт гаргах, хөрөнгө хураан авах ажиллагааны нууцлалыг задруулахгүй байх үүрэгтэй.</p> <p>15.5. Шинжээч тавьсан асуултын заримыг санаатайгаар хариулахгүй орхисон, эсхүл тогтоосон хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн, эсхүл худал дүгнэлт гаргасан бол хуульд заасан <b>хариуцлага хүлээнэ</b>.</p>	<p>хийлгэх шийдвэр гаргаж, шинжээч томилно.</p> <p>2.Шинжээч хийсэн шинжилгээгээ үндэслэн <b>тусгай мэдлэгийн</b> хүрээнд өөрийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргаж, <b>хариуцлага хүлээнэ</b>.</p> <p>3.Шинжилгээ хийлгэх шийдвэрт Шүүх шинжилгээний тухай хуулийн 7.3-т заасан зүйлийг тусгана.</p> <p>4.Шинжээч шинжилгээ хийж, дүгнэлт гаргахдаа энэ хууль, Шүүх шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална.</p> <p>5.Шинжээч гаргасан дүгнэлттэй холбоотой асуудлаар шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирж мэдүүлэг өгнө.</p>
5.	<p><b>16 дугаар зүйл. Мэргэжилтэн</b></p> <p>16.1. Хөрөнгө хураан авах ажиллагааны явцад дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө авах зорилгоор тусгай мэдлэг, эсхүл туршлага бүхий тухайн хэрэгт хувийн сонирхолгүй хүнийг шүүх, прокурор, мөрдөгчийн <b>шийдвэрээр мэргэжилтнээр оролцуулж болно</b>.</p> <p>16.2.<b>Мэргэжилтэн дараах эрхтэй:</b></p> <p>16.2.1. өөрийн оролцож байгаа ажиллагаатай холбогдуулан асуулт тавих;</p> <p>16.2.2. техник хэрэгсэл, төхөөрөмж ажиллуулах;</p> <p>16.2.3. өөрийн оролцсон ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцах, засвар оруулах хүсэлт гаргах;</p> <p>16.2.4. гүйцэтгэсэн ажлын хөлс, зардлыг авах /албан үүргийнхээ хувиар оролцсон энэ заалт хамаарахгүй/;</p> <p>16.2.5. өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангуулах хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргах.</p> <p>16.3. <b>Мэргэжилтэн дараах үүрэгтэй:</b></p> <p>16.3.1. шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирж, өөрийн оролцсон хөрөнгө шалгах ажиллагаатай холбогдуулан мэдүүлэг өгөх;</p> <p>16.3.2. өөрийн оролцсон хөрөнгө шалгах ажиллагаатай холбоотой асуудлаар оролцогчийн асуултад хариулах, тайлбарлах;</p> <p>16.3.3. өөрийн оролцсон хөрөнгө хураан авах ажиллагааны нууцлалыг задруулахгүй байх;</p>	<p>9.3 дугаар зүйл. Мэргэжилтэн</p> <p>1.Шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааны явцад, эсхүл шүүх хуралдаанд ...тусгай мэдлэг, туршлага бүхий хүнийг шүүх, прокурор, мөрдөгчийн <b>шийдвэрээр мэргэжилтнээр оролцуулж болно</b>.</p> <p>2.Мэргэжилтэн дараах эрхтэй:</p> <p>2.1.өөрийн оролцож байгаа ажиллагаатай холбогдуулан асуулт тавих;</p> <p>2.2.техник хэрэгсэл, төхөөрөмж ажиллуулах;</p> <p>2.3.өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах хүсэлт гаргах;</p> <p>2.4.гүйцэтгэсэн ажлын хөлс, зардлыг авах /албан үүргийнхээ хувиар оролцсон бол энэ заалт хамаарахгүй/;</p> <p>2.5.өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангуулах хүсэлт гаргах.</p> <p>3.Мэргэжилтэн дараах үүрэгтэй:</p> <p>3.1.шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирж, өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаатай холбогдуулан мэдүүлэг өгөх;</p> <p>3.2.өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой асуудлаар оролцогчийн асуултад хариулах, тайлбарлах;</p> <p>3.3.өөрийн оролцсон мөрдөн шалгах</p>

		<b>ажиллагааны нууцлалыг задруулахгүй байх.</b>
6.	<p><b>17 дугаар зүйл. Орчуулагч, хэлмэрч</b></p> <p>17.1. Монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол өөрийн эх хэл, эсхүл сайн мэдэх хэл, бичиг, дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан тохиолдолд шүүх, прокурор, мөрдөгч нь орчуулга хийх, хэлмэрчлэх мэдлэг, чадвартай хүнийг орчуулагч, хэлмэрчээр томилно.</p> <p><b>17.2. Орчуулагч, хэлмэрч дараахь эрхтэй:</b></p> <p>17.2.1. өөрийн оролцсон ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах хүсэлт гаргах;</p> <p>17.2.2. орчуулах, хэлмэрчлэх мэдлэг, чадвар хүрэхгүй бол оролцохоос татгалзах;</p> <p>17.2.3. гүйцэтгэсэн ажлын хөлс, зардлыг авах;</p> <p><b>17.3. Орчуулагч, хэлмэрч дараахь үүрэгтэй:</b></p> <p>17.3.1. шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсан цагт хүрэлцэн ирж орчуулах, хэлмэрчлэх;</p> <p>17.3.2. үнэн зөв орчуулж, хэлмэрчлэх;</p> <p>17.3.3. баримт бичиг, эсхүл түүний оролцоотой явагдсан мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлд үнэн зөв орчуулж, хэлмэрчилснийг баталж гарын үсэг зурах;</p> <p>17.3.4. хэлмэрчлэх, орчуулах явцад мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэл, хэргийн, талаарх баримт, мэдээллийг задруулахгүй байх;</p> <p>17.3.5. хөрөнгө хураан авах ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих.</p> <p><b>17.4. Орчуулагч, хэлмэрч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үүргээ биелүүлээгүй, эсхүл санаатай зөрчсөн бол хуульд заасан хариуцлага хүлээнэ.</b></p> <p><b>17.5. Энэ зүйлд заасан журам нь сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг мэдэх хэлмэрчид нэгэн адил хамаарна.</b></p>	<p><b>9.4 дүгээр зүйл. Орчуулагч, хэлмэрч</b></p> <p>1.Энэ хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тохиолдолд шүүх, прокурор, мөрдөгч нь орчуулга хийх, хэлмэрчлэх мэдлэг, чадвартай хүнийг орчуулагч, хэлмэрчээр томилно.</p> <p><b>2.Орчуулагч, хэлмэрч дараахь эрхтэй:</b></p> <p>2.1.өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах хүсэлт гаргах;</p> <p>2.2.орчуулах, хэлмэрчлэх мэдлэг, чадвар хүрэхгүй бол оролцохоос татгалзах;</p> <p>2.3.гүйцэтгэсэн ажлын хөлс, зардлыг авах.</p> <p><b>3.Орчуулагч, хэлмэрч дараахь үүрэгтэй:</b></p> <p>3.1.шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсан цагт хүрэлцэн ирж орчуулах, хэлмэрчлэх;</p> <p>3.2.үнэн зөв орчуулж, хэлмэрчлэх;</p> <p>3.3.баримт бичиг, эсхүл түүний оролцоотой явагдсан мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлд үнэн зөв орчуулж, хэлмэрчилснийг баталж гарын үсэг зурах;</p> <p>3.4.хэлмэрчлэх, орчуулах явцад мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэл, хэргийн талаарх баримт, мэдээллийг задруулахгүй байх;</p> <p>3.5.мөрдөн шалгах ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих.</p> <p><b>4.Орчуулагч, хэлмэрч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үүргээ биелүүлээгүй, эсхүл санаатай зөрчсөн бол хуульд заасан хариуцлага хүлээнэ.</b></p> <p><b>5.Энэ зүйлд заасан журам нь сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг мэдэх хэлмэрчид нэгэн адил хамаарна.</b></p>
		<b>ажиллагааны нууцлалыг задруулахгүй байх.</b>
6.	<p><b>17 дугаар зүйл. Орчуулагч, хэлмэрч</b></p> <p>17.1. Монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол өөрийн эх хэл, эсхүл сайн мэдэх хэл, бичиг, дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан тохиолдолд шүүх, прокурор, мөрдөгч нь орчуулга хийх, хэлмэрчлэх мэдлэг, чадвартай хүнийг орчуулагч, хэлмэрчээр томилно.</p> <p><b>17.2. Орчуулагч, хэлмэрч дараахь эрхтэй:</b></p> <p>17.2.1. өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах хүсэлт гаргах;</p> <p>17.2.2. орчуулах, хэлмэрчлэх мэдлэг, чадвар хүрэхгүй бол оролцохоос татгалзах;</p> <p>17.2.3. гүйцэтгэсэн ажлын хөлс, зардлыг авах;</p> <p><b>17.3. Орчуулагч, хэлмэрч дараахь үүрэгтэй:</b></p> <p>17.3.1. шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсан цагт хүрэлцэн ирж орчуулах, хэлмэрчлэх;</p> <p>17.3.2. үнэн зөв орчуулж, хэлмэрчлэх;</p> <p>17.3.3. баримт бичиг, эсхүл түүний оролцоотой явагдсан мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлд үнэн зөв орчуулж, хэлмэрчилснийг баталж гарын үсэг зурах;</p> <p>17.3.4. хэлмэрчлэх, орчуулах явцад мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэл, хэргийн талаарх баримт, мэдээллийг задруулахгүй байх;</p> <p>17.3.5. хөрөнгө хураан авах ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих.</p> <p><b>17.4. Орчуулагч, хэлмэрч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үүргээ биелүүлээгүй, эсхүл санаатай зөрчсөн бол хуульд заасан хариуцлага хүлээнэ.</b></p> <p><b>17.5. Энэ зүйлд заасан журам нь сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг мэдэх хэлмэрчид нэгэн адил хамаарна.</b></p>	<p><b>9.4 дүгээр зүйл. Орчуулагч, хэлмэрч</b></p> <p>1.Энэ хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тохиолдолд шүүх, прокурор, мөрдөгч нь орчуулга хийх, хэлмэрчлэх мэдлэг, чадвартай хүнийг орчуулагч, хэлмэрчээр томилно.</p> <p><b>2.Орчуулагч, хэлмэрч дараахь эрхтэй:</b></p> <p>2.1.өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах хүсэлт гаргах;</p> <p>2.2.орчуулах, хэлмэрчлэх мэдлэг, чадвар хүрэхгүй бол оролцохоос татгалзах;</p> <p>2.3.гүйцэтгэсэн ажлын хөлс, зардлыг авах.</p> <p><b>3.Орчуулагч, хэлмэрч дараахь үүрэгтэй:</b></p> <p>3.1.шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсан цагт хүрэлцэн ирж орчуулах, хэлмэрчлэх;</p> <p>3.2.үнэн зөв орчуулж, хэлмэрчлэх;</p> <p>3.3.баримт бичиг, эсхүл түүний оролцоотой явагдсан мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлд үнэн зөв орчуулж, хэлмэрчилснийг баталж гарын үсэг зурах;</p> <p>3.4.хэлмэрчлэх, орчуулах явцад мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэл, хэргийн талаарх баримт, мэдээллийг задруулахгүй байх;</p> <p>3.5.мөрдөн шалгах ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих.</p> <p><b>4.Орчуулагч, хэлмэрч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үүргээ биелүүлээгүй, эсхүл санаатай зөрчсөн бол хуульд заасан хариуцлага хүлээнэ.</b></p> <p><b>5.Энэ зүйлд заасан журам нь сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг мэдэх хэлмэрчид нэгэн адил хамаарна.</b></p>

Хуулийн төсөлд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд заасан “Холбогдогч”-той холбоотой зохицуулалттай төслийн 12 дугаар зүйлийг харьцуулан харвал:

#### Хүснэгт 9. Холбогдогч

<b>Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл</b>	<b>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль тухай хууль</b>
<p><b>12 дугаар зүйл. Холбогдогч</b></p> <p>12.1. Хууль бус хөрөнгө байгаа гэх хангалттай үндэслэл бүхий нийтийн албан тушаалтныг холбогдогч гэх бөгөөд дараах эрхтэй:</p> <p>12.1.1. ямар хууль бус хөрөнгөтэй холбогдуулан шалгах ажиллагаа явагдаж байгааг мэдэх;</p> <p>12.1.2. өмгөөлүүлэх;</p> <p>12.1.3. шалгаж байгаа хөрөнгөтэй холбогдуулан тайлбар гаргах;</p> <p>12.1.4. хөрөнгө шалгах ажиллагааны явцад баримт сэлт, нотлох баримт гаргаж өгөх, эсхүл зааж өгөх;</p> <p>12.1.5. тайлбар өгөхөөс татгалзах;</p> <p>12.1.6. гомдол, хүсэлт гаргах;</p> <p>12.1.7. өөрийнх нь хүсэлтээр хийгдэж байгаа хөрөнгө шалгах ажиллагаанд оролцох, уг ажиллагааны тэмдэглэлтэй танилцах, түүнд засвар оруулах хүсэлт гаргах;</p> <p>12.1.8. шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлт, хөрөнгө шалгах ажиллагаа дууссаны дараа хөргийн материалтай танилцах.</p> <p>12.2. Холбогдогч дараах үүрэгтэй:</p> <p>12.2.1. шүүх, прокурор, мөрдөгчийн мэдэгдэх хуудсаар дуудсан цагт хүрэлцэн ирэх;</p> <p>12.2.2. шүүх хуралдааны дэгийг сахих;</p> <p>12.2.3. хөрөнгө шалгах ажиллагааны явцад тухайн хөрөнгийг хууль ёсоор олж авсан талаар тайлбар гаргах, түүнтэй холбоотой баримтыг өөрөө нотлох, нотлох баримтыг цуглуулах, гаргаж өгөх;</p> <p>12.2.4. хөрөнгө хураан авах ажиллагааны явцад санаатай саад учруулахгүй байх, шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэр, хууль ёсны шаардлагыг биелүүлэх;</p> <p>12.2.5. бусад оролцогчид нөлөөлөхгүй байх;</p> <p>12.3. Холбогдогч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй нь хуульд заасны дагуу албадлага хэрэглэх, хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.</p> <p>12.4. Холбогдогчийг шүүхийн шатанд зохигч буюу хариуцагч гэх бөгөөд шүүхийн шатанд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.</p>	<p><b>3.1 дүгээр зүйл.Холбогдогч</b></p> <p>1.Зөрчил үйлдсэн гэж буруутгагдаж байгаа хүн, хуулийн этгээдийг холбогдогч гэнэ.</p> <p>2.Холбогдогч дараахь эрхтэй:</p> <p>2.1.ямар зөрчилд холбогдон шалгагдаж байгааг мэдэх;</p> <p>2.2.өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах;</p> <p>2.3.эх хэлээрээ, эсхүл сайн мэдэх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;</p> <p>2.4.хохирогчийн гомдолтой танилцаж тайлбар гаргах;</p> <p>2.5.зөрчил шалгах тодорхой ажиллагаа явуулах хүсэлт гаргах;</p> <p>2.6.эрх бүхий албан тушаалтан, хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан, прокурорын үйл ажиллагаа, шийдвэр, шүүхийн шийдвэрт гомдол гаргах;</p> <p>2.7.өөрийн, эсхүл хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу хийгдэж байгаа зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцох, уг ажиллагааны тэмдэглэлтэй танилцах, түүнд засвар оруулах хүсэлт гаргах;</p> <p>2.8.нотлох баримт шалгуулах тухай хүсэлт гаргах, нотлох баримт гаргаж өгөх;</p> <p>2.9.зөрчлийн хэрэгтэй танилцах;</p> <p>2.10.хуульд заасан бусад.</p> <p>3.Холбогдогч дараахь үүрэгтэй:</p> <p>3.1.шүүх, прокурор, эрх бүхий албан тушаалтны дуудсан цагт хүрэлцэн ирэх;</p> <p>3.2.шүүх, прокурор, эрх бүхий албан тушаалтны шийдвэр, хууль ёсны шаардлагыг биелүүлэх;</p> <p>3.3.зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх;</p> <p>3.4.оролцогчид нөлөөлөхгүй байх.</p> <p>4.Холбогдогчийн энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй нь түүнд эрх хязгаарлах арга хэмжээ хэрэглэх, хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.</p>

#### Өмгөөлөгч

**Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Нийтийн албан тушаалтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа авах эрхээр хангах зорилгоор хөрөнгө шалгах ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулах бөгөөд өмгөөлөгч**

дараах эрхтэй” гэж заасан нь тус ажиллагаанд зөвхөн нийтийн албан тушаалтан л өмгөөлүлэх эрхтэй хэмээн ойлгогдож байна. Гэтэл нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаанд зөвхөн нийтийн албан тушаалтан оролцоогүй гэрч, хууль ёсны эрх ашиг нь хөндөгдөж буй бусад оролцогчид гээд олон оролцогч оролцож буй тухай хуулийн төслийн энэ бүлэг болон өмнөх бүлгүүдээс тодорхой харагдана. Гэтэл өмгөөлөгч эдгээр оролцогчдоос зөвхөн нийтийн албан тушаалтныг л өмгөөлөхөөр ийнхүү заасан байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14-т хүн бүр хууль зүйн туслалцаа авах эрхтэй гэж заасанд нийцэхгүй байна.

Хуулийн төсөлд өмгөөлөгчийн эрх, үүргийг тодорхойлохдоо Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалттай ижил байдлаар зохицуулсан гэж үзэж болох юм. Учир нь хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 болон 11.1.7 дахь заалт нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаа дахь өмгөөлөгчийн статусыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай “нэгэн адил” байна.

**Хуулийн төслийн 11.1.4-т** “хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурорт гаргаж өгөх, түүнийг хэрэгт бэхжүүлж тусгүүлах, хөрөнгө шалгах ажиллагааны явцад тодорхой төрлийн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах” гэж заасан нь өмгөөлөгч тус ажиллагаанд нотлох баримт цуглуулах эрхгүй зөвхөн гаргаж өгөх бөгөөд хэрэгт авагдах эсэхийг мөрдөгч, прокурор шийдэх эрхтэй, мөн тэдгээрт тодорхой төрлийн ажиллагаа явуулахаар хүсэлт л гаргах эрхтэй байхаар ойлгогдож байна. Мөн хуулийн төслийн 11.1.7-д “хөрөнгө шалгах ажиллагааны явцад өөрсдийнх нь зөвшөөрснөөр хүн, хуулийн этгээдээс хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулж авах” гэж заасан нь өмгөөлөгчийг энэхүү ажиллагаанд эрх, үүргийн хэт тэнцвэргүй байдалд оруулж байна.

**Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 болон 11.3 дахь хэсэгт хугацаа сунгах эрх бүхий прокурор, мөрдөгчийн **төвлөсон хугацаанд** хөрөнгө шалгах ажиллагаанд оролцох ёстой бөгөөд тус ажиллагаанд оролцох болсноо үйлчлүүлэгчийнхээ бичгээр үйлдсэн хүсэлтээр баталгаажуулж бичгээр прокурор, мөрдөгчид мэдэгдэх үүргийг тус тус хүлээлгэсэн байна. Ийнхүү прокурор, мөрдөгчийн өмнө үүрэг хүлээж байгаа нь энэхүү ажиллагааны дараа дараагийн шатанд иргэний процессын хууль тогтоомж хэрэглэх боломжгүй болгож, хэрэв хэрэглэх тохиолдолд эрх зүйн онолын болон эрх зүйн зэрчил бий болгохоор байна.**


Мөн прокурор, мөрдөгч нь эрүүгийн процессын нэгэн адил нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаанд тус процесс ажиллагааг хэрэгжүүлэгч болохыг, харин өмгөөлөгч оролцогч болохыг нотлон илтгэж байна.

### **3.4. Хууль бус хөрөнгө хураан авах ажиллагаанд хүсэлт, гомдол гаргах тухай зохицуулсан тус хуулийн 18-24 дүгээр зүйл**

#### **1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт “Хууль бус хөрөнгө хураан авах ажиллагаанд хүсэлт, гомдол гаргах” зохицуулалтыг тусгасан байна. Энэхүү зохицуулалтууд нь тус төслийн 1.1-д заасан “...хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх эрх зүйн үндсийг тогтоох...” зорилгодоо хүрч байна. Учир нь хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх эрх зүйн үндсийг тогтооход хөрөнгө хураан авах ажиллагаанд оролцогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө хураан авах ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн уг ажиллагааны оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээд шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гомдол гаргах эрхийг тусгах асуудал хөндөгдж байдаг. Иймд тус бүлэгт заасан зохицуулалтыг зорилгодоо хүрсэн гэж үзсэн болно.

**Схем 1. Хууль бус хөрөнгө шалгах ажиллагаанд гомдол гаргах**



Гомдлыг хүлээн авсан прокурор 14 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд нэмэлт материал шалгах, эсхүл бусад арга хэмжээ авах бол 21 хоногийн дотор хянаж, тухайн шийдвэр, ажиллагааг хүчингүй болгох, өөрчлөх, эсхүл гомдолыг хүлээн авахаас татгалзсан тухай шийдвэр гаргана.

Гомдол гаргагч шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол тус шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор дээд шатны прокурорт гомдол гаргаж болно.

## 2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт:

- 18 дугаар зүйл. Хүсэлт, гомдол гаргах
- 19 дүгээр зүйл. Хүсэлт, гомдол гаргах журам
- 20 дугаар зүйл. Хүсэлтийг шийдвэрлэх
- 21 дүгээр зүйл. Гомдлыг шалган шийдвэрлэх нийтлэг журам
- 22 дугаар зүйл. Мөрдөгч, прокурорын шийдвэр, ажиллагаанд гаргасан гомдлыг хянах
- 23 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрт гомдол гаргах
- 24 дүгээр зүйл. Хүсэлт, гомдлыг хавтаст хэрэгт хавсаргах
- 25 дугаар зүйл. Хууль бус хөрөнгө хураан авах ажиллагаанд хүсэлт, гомдол гаргах” зохицуулалтыг тусгасан байна.

### Схем 2. Хууль бус хөрөнгө хураан авах ажиллагаанд хүсэлт, гомдол гаргах

#### Хүсэлт:

Хөрөнгө хураан авах ажиллагаанд оролцогч өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах тухай хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргах эрхтэй.  
(18 дугаар зүйлийн 18.1 дахь хэсэг)

#### Гомдол:

Хөрөнгө хураан авах ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн уг ажиллагааны оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээд нь шүүх, прокурор, мөрдөгчийн ажиллагаанд гомдол гаргах эрхтэй.  
(18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг)

Тухайн ажиллагааг явуулж буй шүүх, прокурор, мөрдөгчид хандан хүсэлт гаргана.

Хуульд заасны дагуу хяналт тавих, шийдвэр гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандан гаргана.

Шүүх, прокурор, мөрдөгч нь ирүүлсэн хүсэлтэд үндэслэн хөрөнгө хураан авах ажиллагааны явцад оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолтой бол бүрэн, эсхүл хэсэгчлэн хангах, хүсэлтийг хангахаас татгалзах тухай шийдвэр гаргана.

- Хуульд заасны дагуу хяналт тавих, шийдвэр гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь ирүүлсэн гомдолын үндэслэлийг тал бүрээс нь хянаж шаардлагатай бол нэмэлт баримт гаргуулж, тайлбар авч болно.

- Гомдол гаргачийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээг цаг алдартгүй авна.

- Хууль бус шийдвэр, ажиллагааны улмаас гомдол гаргачийн эд хөрөнгө, эрүүл мэндэд хохирол учирсан бол хуульд заасан журмын дагуу хохирлоо арилггуулахаар хандах эрхтэй болохыг тайлбарлана.

Хүсэлтийг хангах үндэслэл нь тодорхой, даруй шалгах шаардлагатай тохиолдолд хүсэлтийг гаргаснаас хойш ажлын 5 хоногт шийдвэрлэнэ.

Прокурор, оролцогч хөрөнгө хураан авах ажиллагааны явцад гаргасан шүүхийн шийдвэрийг эс зөвөөрөөл 3 хоногийн дотор гомдол гаргаж болно.


Хуулийн төслийн энэхүү зохицуулалтууд нь ЭХХШТХ-ийн Арван тавдугаар бүлэгт заасан “Хүсэлт, гомдол гаргах” зохицуулалттай агуулгын хувьд ижил байна. Өөрөөр хэлбэл, практикт хэрэгжих буй ЭХХШТХ-д заасан хүсэлт, гомдол гаргах зохицуулалттай ижил учир хуулийн төслийн энэ бүлэгт заасан зохицуулалт практикт хэрэгжих боломжтой гэж дүгнэлээ.

### 3.5. Нотлох баримтын тухай зохицуулсан тус хуулийн 25-27 дугаар зүйл

#### 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн тавдугаар бүлэгт “Хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааны нотлох баримт”-ыг тусгасан байна. Төслийн 25.2-т “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Авлигын эсрэг хууль, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулсан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцно” гэж заажээ. Гэтэл хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэхтэй холбоотой нэхэмжлэлийг иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргахаар тус хуулийн төслийн 55.1-д заасан байна. Өөрөөр хэлбэл, тухайн нотлох баримтыг үндэслэн, нэхэмжлэлийг иргэний хэргийн шүүх шийдвэрлэх бөгөөд ИХХШТХ-д заасан нотлох баримттай холбоотой зохицуулалтыг тус төслийн 25.2-т тусгаагүй нь учир дутагдалтай байна. Иймд тус бүлэгт заасан нотлох баримттай холбоотой зохицуулалт хуулийн төслийн 1.1-д заасан зорилгодоо бүрэн хүрч чадаагүй байна гэж үзлээ.

**Схем 3. Хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа /нотлох баримт цуглуулах/**



## **2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Хуулийн төслийн тавдугаар бүлэгт:

- 25 дугаар зүйл. Нотлох баримт
- 26 дугаар зүйл. Нотлох баримтыг үнэлэх зохицуулалтыг тусгажээ.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дурдсанчлан энэ бүлэгт заасан зохицуулалт нь ЭХХШТХ-д нотлох баримт цуглуулахтай холбоотой зохицуулалттай илүү уялдаж байна. Гэтэл хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг хянан шийдвэрлэхдээ ЭХХШТХ биш ИХШХШТХ-ийг баримтлахаар тусгасан. Иймд тус бүлэгт заасан нотлох баримттай холбоотой зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхийн тулд тус зохицуулалтын асуудлыг сайтар судлан үзэж, засаж сайжруулах нь зүйтэй.

## **3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Хуулийн төслийн 25 дугаар зүйлд нотлох баримтыг тодорхойлсон байна. Тус зүйлийн 25.1-д “Энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу цуглуулсан баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.” гэж заасан нь нотлох баримтыг зөвхөн энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу цуглуулсан бол нотлох баримт гэж тооцно гэх агуулгатай ч мөн зүйлийн 25.2-т “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Авлигын эсрэг хууль, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулсан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцно.” гэж заасан дээрх төслийн 25.1 дэх хэсгийг үгүйсгэж байна. Иймд 25 дугаар зүйлд заасан 25.1, 25.2 дахь заалтууд хоорондоо зөрчилдөж байна.

Нотлох баримтыг хэн буюу ямар субъект цуглуулах вэ гэдэг процессын эрх зүйн хамгийн чухал ойлголтын нэг юм. Үүгээр шалгуур болгон салбар эрх зүйг тодорхойлох бусад эрх зүйн салбараас ялгах хүртэл боломжтой.

Эрүүгийн процесст нотлох баримтыг цуглуулахад төрийн байгууллагын оролцоо харьцангуй их байдаг. Монгол Улсын хувьд нотлох баримт цуглуулах эрх зөвхөн процесс ажиллагааг хэрэгжүүлэгчид байдаг онцлогтой. Үүнийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлийн 4-т “Мөрдөгч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу нотлох баримт цуглуулж, шалгаж, бэхжүүлнэ.” гэж зааснаас харж болно.

Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдол бүхий үйл баримтыг шүүхэд толилуулах, тэдгээрийг нотлох үүргийг зохигч талууд хүлээдэг.<sup>19</sup> Энэ тухай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д “Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.” хэмээн заасан байдаг. Харин нотлох баримт бүрдүүлэх үүргийг шүүх хүлээдэг.

<sup>19</sup> Б.Буянхишиг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, (УБ, 2021), 103 дахь тал.

**Нотлох баримт цуглуулах тухай хуулийн төслийн 26 дугаар зүйлд зохицуулахдаа нотлох баримт цуглуулах эрхийг зөвхөн мөрдөгч, прокурорт олгож өмгөөлөгчийн тухайд огт дурдаагүй байна. 26 дугаар зүйлийн 26.1-д зааснаар мөрдөгч, прокурор хөрөнгө шалгах ажиллагаа явуулахдаа хаалттай болон хязгаарлалттай мэдээлэл агуулсан баримт бичиг, мэдээллийг цуглуулах эрхтэй ба тус зүйлийн 26.2-т зааснаар нотариат, банк, даатгалын болон арилжааны нууц, банк, банк бус санхүүгийн байгууллага дахь гүйлгээ, зээлийн нэмэлт мэдээлэл гаргуулан авах эрхтэй ажээ. Үүгээр зогсохгүй 26.4-т зааснаар мэдээллийг гаргаж өгсөн этгээд нь тухайн ажиллагаа явуулсан нууцлалыг хангах үүрэгтэй бөгөөд, зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнгэхээр заасан нь эрүүгийн процесс дахь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцыг хадгалахтай адил зохицуулалт байна.**

Харин өмгөөлөгч нотлох баримттай холбоотой ямар эрх эдэлж, үүрэг хүлээх тухай **Хуулийн төслийн 11.1.4-т** "...шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурорт гаргаж өгөх, түүнийг хэрэгт бэхжүүлж тусгүулах, хөрөнгө шалгах ажиллагааны явцад тодорхой төрлийн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах" гэж заасан нь өмгөөлөгч тус ажиллагаанд нотлох баримт цуглуулах эрхгүй зөвхөн гаргаж өгөх бөгөөд хэрэгт авагдах эсэхийг мөрдөгч, прокурор шийдэх эрхтэй, мөн тэдгээрт тодорхой төрлийн ажиллагаа явуулахаар хүсэлт л гаргах эрхтэй байхаар ойлгогдож байна. Мөн зүйлийн 11.1.7-д "хөрөнгө шалгах ажиллагааны явцад **өөрсдийнх нь зөвшөөрснөөр** хүн, хуулийн этгээдээс хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуйж авах" гэж заасан нь **процессын тэгш оролцоо, тэнцвэрийн зарчмыг** зөрчиж байна. Мөн түүнчлэн, хуулийн төслийн 27.1-д шүүх шийдвэрээ зөвхөн прокурор, мөрдөгчийн цуглуулсан нотлох баримтын хүрээнд гаргахаар заажээ.

Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг хянан шийдвэрлэхдээ ЭХХШтХ биш ИХШХШтХ-ийг баримтлахаар тусгасан байгаа тухай өмнөх хэсэгт дурдсан. Иймд нотлох баримт цуглуулахтай холбоотой ИХШХШтХ-ийг хэрэглэх ёстой буюу иргэний процессын эрх зүйд хуулийн төслийн зохицуулалт нийцсэн байх ёстой.

Иргэний процессын гол зарчим болох талуудын зарчим нь дараах агуулгатай байдаг. Үүнд:

- Талууд процесс хэрхэн өрнөх, ямар нотлох баримт бүрдүүлэх, ямар хуулийн хамгаалалт авахаа өөрсдөө бие даан шийдэх эрхтэй
- Талуудын аль аль нь өөрсдийн аргумент нотлох баримтаа санал болгох, сонсгох адил тэгш боломж олгох ба шүүх тэдгээрийг нейтрал байр сууринаас шинжлэн судалж шийдвэр гаргана.
- Талууд шаардлагаа холбогдох нотлох баримтаар баталгаажуулах үүрэгтэй. Шаардлага гаргаж байгаа тал нотлох үүрэг хүлээнэ.
- Талуудын идэвхтэй оролцоо заавал байна. Шүүхэд хүсэлт гаргах, нотлох баримт гаргаж өгөх, мэдүүлгийг няцаах зэргээр процесст идэвхтэй оролцоно.<sup>20</sup>

<sup>20</sup> Б.Буянхишиг, Иргэний процесс дахь нотолгооны эрх зүй, (УБ, 2024), 7 дахь тал.


Эндээс харвал нотлох баримт цуглуулахтай холбоотой хуулийн төслийн зохицуулалт нь иргэний процессын эрх зүйн үндсэн зарчимд нийцэхгүй байна. Мөн түүнчлэн ИХШХШТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мэтгэлцэх үндсэн дээр хэрэгжүүлнэ.” гэж, 6.2-т “Мэтгэлцэх зарчим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хэрэгжинэ.” гэж, 6.4-т “Зохигч ...нотлох баримт гаргах, түүнийг шинжлэн судлахад тэгш эрхтэй оролцно.” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

### 3.6. Хууль бус хөрөнгийг шалгах ажиллагааны тухай зохицуулсан тус хуулийн 28-51 дүгээр зүйл

#### 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн зургаадугаар бүлэгт “Хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа”-г тусгасан. Төслийн 29.1-д “Прокурор нь хууль бус хөрөнгөтэй холбоотой хөрөнгө шалгах ажиллагааны явцад мэдэгдэж буй нөхцөл байдлыг үндэслэн шалгах ажиллагаа явуулах тухай шийдвэр гаргахдаа шалгах ажиллагаанд 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш бий болсон хууль бус хөрөнгийг хамруулна” гэж заасан.


**Схем 4. Хууль бус хөрөнгө шалгах ажиллагааг эхлүүлэх**



Хөрөнгө шалгах ажиллагааны харьяаллыг ЭХХШТХ-д заасны дагуу тогтооно.

Хуулийн төслийн 1.1-д "...Энэ хуулийн зорилго нь нийтийн албан тушаалтны хууль ёсны орлогын эх үүсвэрээс давсан, түүний шууд болон шууд бус өмчлөл, эзэмшилд байгаа, эрхэлж байсан болон эрхэлж байгаа албан тушаалын эрх нөлөөгөөр бий болсон, хууль ёсны эх үүсвэр тодорхойгүй, эсхүл хууль бус аргаар олж авсан эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлогыг хурааж авах, нехөн төлүүлэх эрх зүйн үндэслэлийг тогтоо замаар нийтийн алба дахь авлигыг таслан зогсоох, дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, авлигагүй нийтийн албыг бий болгоход оршино..." гэж заасан. Гэтэл манай улсын хувьд 2006 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн "Авлигын эсрэг хуульд анх удаа "нийтийн албан тушаалтан" гэх нэр томьёог хуульчилж өгсөн. Үүнээс өмнө буюу 2002-2006 оны хооронд нийтийн албан тушаалтан гэх ойлголт хуульд тусгагдаагүй байсантай холбоотойгоор тухайн үед одоогийн "нийтийн албан тушаалтан"-д хамаарах албан тушаалд ажиллаж байсан албан хаагчдыг 2006 оны Авлигын хуульд заасан ойлголтод хамааруулан авч үзэх нь тохиромжгүй харагдаж байна. Иймд хуулийн төслийн тус зохицуулалт зорилгодоо бүрэн хүрээгүй гэж үзсэн болно. Мөн энэхүү зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болохыг дурдах нь зүйтэй.

#### **Схем 5. Хууль бус хөрөнгө шалгах ажиллагаан дахь прокурорын оролцоо**



## **2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Төслийн зургадугаар бүлэгт заасан хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаатай холбоотой зарим зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Тухайлбал, “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн төслийн 29.1-д “Прокурор нь хууль бус хөрөнгөтэй холбоотой хөрөнгө шалгах ажиллагааны явцад мэдэгдэж буй нөхцөл байдлыг үндэслэн шалгах ажиллагаа явуулах тухай шийдвэр гаргахдаа шалгах ажиллагаанд 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш бий болсон хууль бус хөрөнгийг хамруулна” гэж заасан зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна.

Нэг талаас зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд дурдсанчлан “нийтийн албан тушаалтан” гэх нэр томьёо Авлигын эсрэг хуульд 2006 онд анх хуульчлагдсан бөгөөд үүнээс өмнө нийтийн албан тушаалтан гэх нэр томьёо хуульчлагдаагүй байсан. Нөгөөтээгүүр, цаг хугацааны хувьд 2002 он буюу одоогоос 23 жилийн өмнөх үе болохын хувьд зарим тохиолдолд тухайн хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч өөрийн хөрөнгийг шударгаар олж авсан гэдгийг нотлоход хүндрэлтэй байх магадлалтай. Энэ нь хүний эрхийг ноцтой зөрчих нөхцөлийг бүрдүүлж болох юм.

Мөн хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа явуулахад цаг хугацааны хувьд хүндрэлтэй, зарим хэргийг илрүүлэх, бодит нөхцөл байдлыг тогтооход маш их хөрөнгө, хүч, зардал шаардаж болохоор байна. Иймд тус зохицуулалтыг сайтар нягталж үзэх шаардлагатай.

Түүнчлэн, төслийн 28 дугаар зүйлд заасан хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа явуулах талаарх зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хэд хэдэн асуудал үүсэж болзошгүй байна. Тухайлбал, Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон нийтийн албан тушаалтантай холбоотой хэргүүдийг шалгахад хүний нөөц, зардлын хувьд боломжтой эсэх. Одоогийн байдлаар шүүх, прокурор, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллагуудад хүний нөөц, боловсон хүчин, ажлын ачаалал, төсвийн хүрэлцээтэй холбоотой асуудлууд тулгамдаж байна.

Мөн Улсын Ерөнхий Прокурорын газрын Эрүүгийн хэргийн төв архив болон бусад архивд хадгалагдаж буй гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон хавтаст хэргийн хадгалах хугацаа дуусаж устгалд орсон байх боломжтой. Энэ мэтчилэн төслийн 28.1.2-т заасан 5 үндэслэлийн нэг л үндэслэлийн хүрээнд гэхэд энэ мэт практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй асуудал нэлээдгүй байна.

Төслийн 28 дугаар зүйлийн 28.1.2.б дэд заалтад заасан “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд хамрагдсан” гэх зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд мөн хүндрэлтэй асуудал тогтоогдсон. Үүнийг энэхүү судалгааны ажлын “харилцан уялдаа” хэсэгт дэлгэрэнгүй бичсэн болно.

### 3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн 28-51 дүгээр зүйлд Хууль бус хөрөнгийг шалгах ажиллагааны тухай зохицуулжээ. Судалгааны 3.3 дугаар хэсэгт нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааны хэрэгжүүлэгч нь эрүүгийн процесс ажиллагааны хэрэгжүүлэгчтэй адил бөгөөд бүрэн эрхийн тухай зохицуулалт нь төсөөтэй байгаа тухай өгүүлсэн билээ. Иймд хууль бус хөрөнгийг шалгах тодорхой ажиллагааны тухай зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай харьцуулан авч үзэхийг шаардлагатай гэж үзлээ.

**Хүснэгт 10.** Хууль бус хөрөнгийг шалгах тодорхой ажиллагааны тухай зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай харьцуулсан нь

№	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
1.	32 дугаар зүйл.Үзлэг хийх 32.1.Хөрөнгө шалгах ажиллагаанд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоох, тодруулах зорилгоор хүний бие, эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, мал, амьтан, тодорхой газар, орон байранд үзлэг хийнэ.	23.1 дүгээр зүйл.Үзлэг хийх 1.Мөрдөгч гэмт хэрэг гарсан байдал, хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг тогтоох, тодруулах зорилгоор хүний бие, эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, мал, амьтан, хэрэг гарсан газарт үзлэг хийнэ.
2.	33 дугаар зүйл.Нэгжлэг хийх 25.1.Мөрдөгч хөрөнгө шалгах ажиллагаанд ач холбогдолтой баримт бичиг, эд зүйл, эсвэл нотлох баримт байна гэх хангалттай үндэслэл байвал тэдгээрийг илрүүлэхээр прокурорын зөвшөөрөлд заасан орон байр, бусад газар, хүний биед нэгжлэг хийнэ.	24.1 дүгээр зүйл. Нэгжлэг хийх 1. <i>Мөрдөгч</i> хэргийн эд мериин баримт, бичмэл нотлох баримт, эсхүл эрэн сурвалжилж байгаа хүн, эд зүйл байна гэх хангалттай үндэслэл байвал тэдгээрийг илрүүлэхээр прокурорын зөвшөөрөлд заасан орон байр, бусад газар, хүний биед нэгжлэг хийнэ.
3.	34 дүгээр зүйл.Тайлбар, мэдүүлэг 34.1.Мөрдөгч нь холбогдогч, гэрч, шинжээч, мэргэжилтэн, бусад оролцогчоос хөрөнгө шалгах ажиллагаанд ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар, шинжээч, мэргэжилтнээс гаргасан дүгнэлт, оролцсон ажиллагааных нь талаар тайлбарлуулах, эсхүл тодруулах зорилгоор тайлбар, мэдүүлэг авч болно.	25.1 дүгээр зүйл. Мэдүүлэг авах 1. Гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад энэ бүлэгт заасан нийтлэн журмыг баримтална.
4.	35 дугаар зүйл.Тайлбар, мэдүүлгийг газар дээр нь шалгах 35.1.Илэрсэн нөхцөл байдлыг шалгах, явсан замыг тогтоох, зааж өгсөн газрыг шалгах, урьд өгсөн тайлбар, мэдүүлгийн үнэн зөвийг харьцуулан тогтоох зорилгоор тайлбар, мэдүүлгийг газар дээр нь шалгаж болно.	25.6 дугаар зүйл. Мэдүүлгийг газар дээр нь шалгах 1.Илэрсэн нөхцөл байдлыг шалгах, явсан замыг тогтоох, зааж өгсөн газрыг шалгах, урьд өгсөн мэдүүлгийн үнэн зөвийг харьцуулан тогтоох зорилгоор яллагдагчийн зөвшөөрснөөр, эсхүл мөрдөгч өөрийн санаачилгаар мэдүүлгийг газар дээр нь шалгаж болно.
5.	36 дугаар зүйл.Таньж олуулах 36.1.Мөрдөгч хөрөнгө шалгах ажиллагаанд ач холбогдолтой нөхцөл байдлыг тогтоох, тодруулах зорилгоор хүн, мал, амьтан, эд зүйл, тодорхой газар, орон байрыг таньж олуулж болно.	25.7 дугаар зүйл. Таньж олуулах 1.Мөрдөгч хүн, мал, амьтан, цогцос, эд зүйл, тодорхой газар, орон байрыг гэрч, хохирогч, яллагдагчаар таньж олуулж болно.

6.	<p><b>37 дугаар зүйл.Шинжилгээ хийлгэх</b></p> <p>37.1.Хөрөнгө шалгах ажиллагааны явцад эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоохоор, эсхүл тусгай мэдлэг зайлшгүй шаардлагатай бол шүүх, прокурор, мөрдөгч шийдвэр гаргаж шинжилгээ хийлгэнэ.</p>	<p><b>27.1 дүгээр зүйл. Шинжилгээ хийлгэх журам</b></p> <p>1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоохоор, эсхүл тусгай мэдлэг зайлшгүй шаардлагатай бол шүүх, прокурор, мөрдөгч шийдвэр гаргаж шинжилгээ хийлгэнэ.</p>
7.	<p><b>38 дугаар зүйл.Эд хөрөнгө битүүмжлэх</b></p> <p>38.1.Хохирлыг нөхөн төлүүлэх, хууль бус хөрөнгийг хураах, нөхөн төлүүлэх зорилгоор нийтийн албан тушаалтны хөрөнгийг шүүх, прокурорын шийдвэрээр битүүмжилнэ.</p>	<p><b>21.2 дугаар зүйл. Эд хөрөнгө битүүмжлэх</b></p> <p>1.Хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршигийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийг шүүх, прокурорын шийдвэрээр битүүмжилнэ.</p>
8.	<p><b>39 дүгээр зүйл.Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах</b></p> <p>39.1.Мөрдөгч хэрэгт ач холбогдолтой хөрөнгийг нуух, устгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг байвал прокурорын зөвшөөрлөөр хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах ажиллагааг явуулна.</p>	<p><b>26.1 дүгээр зүйл. Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах</b></p> <p>1.Мөрдөгч гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон байж болох, эсхүл хэрэгт ач холбогдолтой хөрөнгийг нуух, устгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг байвал прокурорын зөвшөөрлөөр дараахь ажиллагаа явуулна:</p> <p>1.1.ул хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахыг зохих байгууллагад даалгах.</p> <p>1.2.ул хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахыг зохих байгууллагад даалгах.</p> <p>2.Энэ зүйлийн 1.1-д заасан ажиллагааг проクурорын зөвшөөрлөөр нууцаар явуулж болно.</p>
9.	<p><b>40 дүгээр зүйл.Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах</b></p>	<p><b>24.5 дугаар зүйл. Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах</b></p>

	40.1. <b>Мөрдөгч</b> хаалттай болон хязгаарлалттай мэдээлэл эсэхээс үл хамааран эрүүгийн <b>хэрэгт ач холбогдол бүхий аливаа мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авна.</b>	1. <b>Мөрдөгч</b> төрийн нууц, хувь хүний эрүүл мэнд, захидал харилцааны нууцтай холбоотой эрүүгийн <b>хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авна.</b>
10.	<b>41 дүгээр зүйл.Түр хураан авах</b> 41.1.Хөрөнгө шалгах ажиллагааны явцад дараах үндэслэл байвал хууль бус байж болзошгүй хөрөнгийг хамгаалах зорилгоор түр хураан авч болно: 41.1.1.хөрөнгийг устгах, захиран зарцуулах, өмчлөгч, эзэмшигчийг өөрчлөх; 41.1.1.хөрөнгийн үнийг илтэд нөлөөлөх бодит нөхцөл бий болсон; 41.1.2.хөрөнгийг гэмт хэрэг үйлдэхэд ашиглах боломжтой; 41.1.3.тухайн хөрөнгө үрэгдэх, тоногдох, шинж чанарыг өөрчлөх болон хөрөнгийг цаашид хураах боломжгүй болгох бусад эрсдэл байвал. 41.2.Түр хураан авахад мөрдөгч, прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ. 41.3.Түр хураан авах тогтоолд тухайн хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчийн мэдээлэл, хөрөнгийн талаарх мэдээлэл, хөрөнгийн баримт бичиг, хууль бус хөрөнгө гэж үзэх үндэслэлтэй нөхцөл байдал, тухайн хөрөнгийг түр хураан авах шаардлага, нөхцөл байдал, түр хураах хугацааны талаар тусгана.	-

Дээрх хүснэгтээс дүгнэвэл, Хууль бус хөрөнгийг шалгах тодорхой ажиллагааны төрөл, нэршил, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь ЭХХШтХ-д заасан мөрдөн шалгах тодорхой ажиллагаатай адил буюу төсөөтэй байдлаар зохицуулжээ. Эндээс процессын хэрэгжүүлэгч, оролцогчид адил, тэдгээрийн эрх, үүрэг буюу процесс ажиллагаан дахь статус ижил төсөөтэй, мөн үүн дээр хууль бус хөрөнгийг шалгах тодорхой ажиллагаа нь мөрдөн шалгах тодорхой ажиллагаатай ч ижил төсөөтэй байх тул хууль бус хөрөнгө, шалгах, хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаа нь **эрүүгийн процессын шинжтэй хэмээн дүгнэх хангалттай үндэслэл** болж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо нь үндсэндээ **аккусаци /adversarial system/** болон **инквизицийн /inquisitorial system/** хэв маягтай хэмээн ангилагддаг. Манай улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүхийн өмнөх шатанд инквизицийн загварын **/inquisitorial system/** шинжтэй. Харин шүүхийн шатанд Аккусацийн загварын **/Adversarial system/** шинжтэй.

Шүүхийн өмнөх шатанд мөрдөгч, прокурор нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоож хуульд заасан бүх арга хэмжээг авч яллагдагч, шүүгдэгчийг яллах, цагаатгах, ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтоох үүргийг хүлээдэг. Өөрөөр хэлбэл шүүхийн өмнөх шатанд прокурор гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл хүлээн авахаас эрүүгийн хэрэг үүсгэх, хаах, шүүхэд шилжүүлэх хүртэлх бүхий л процесс хяналт тавьж шийдвэрлэх үүрэгтэй оролцдог. Иймд шүүхийн өмнөх шатанд **инквизицийн загвар /inquisitorial system/** хэв маягтай.

Шүүхийн шатанд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн бодит байдлыг тогтоох зарчмын хүрээнд шүүх хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтоох ёстой гэж үздэг. Өөрөөр хэлбэл яллах болон өмгөөлөх талууд шүүхийн процесст тэгш эрхтэй оролцогчид болдог. Харин сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардахыг хориглодог. Иймд энэ шатанд **Аккүсацийн хэв маягтай /Adversarial system/** байна..

**Инквизицийн тогтолцоо** нь хаалттай, хязгаарлалт бүхий **мэтгэлцээний бус систем юм.**<sup>21</sup> Өөрөөр энэ тогтолцоог Мөрдөн байцаах тогтолцоо гэж нэрлэдэг бөгөөд эх газрын эрх зүйн тогтолцоонд хамаардаг. Өдгөө дэлхийн улс орнуудын хувьд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны зонхилох чиг хандлага болсон байна. Энэхүү тогтолцоо нь **хэргийн бодит үнэнийг тогтоох** талыг илүү түлхүү барьж, хуульд заасан хугацаа, үе шатыг дамжин хэрэгждэг. Тийм ч учир хэргийн үнэн бодит байдлыг бүх талаас нь бүрэн гүйцэд шалган тогтоохын тулд хэргийн онцлог, ангиллаас үл хамаарч **мөрдөн байцаалтыг заавал явуулах шаардлага тавигддаг.**<sup>22</sup> Мөрдөн байцаалтын ажиллагааг үнэнийг тогтоох албан ёсны хэрэг бүртгэлт гэж тодорхойлж болох бөгөөд мөрдөн байцаалтын ажиллагаа нь тухайн үйл явцыг хянадаг шүүгчид илүү их эрх мэдлийг олгодог.<sup>23</sup>

Дээрхээс дүгнэвэл, хууль бус хөрөнгө, шалгах, хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаа нь эрүүгийн процесс тэр дундаа **мөрдөн шалгах ажиллагааг зайлшгүй хийгдэхийг шаарддаг, талуудын тэгш буюу тэнцвэртэй оролцоог хязгаарласан мэтгэлцэх зарчмыг үгүйсгэсэн инквизицийн хэв маягтай байна.** Хүний хөрөнгийг хураах буюу өмчлөх эрхийг нь хязгаарлах үгүйсгэх үр дагавар бүхий тус ажиллагаа эрүүгийн процессын инквизицийн хэв маягтай хэрэгжихээр байгаа нь Монгол Улсын өдийг хүртэл тогтсон эрх зүйн уламжлал, эрх зүйн тогтолцоог бүхэлд нь үгүйсгэх ноцтой үр дагаварыг үүсгэж болзошгүй юм.

<sup>21</sup> Д.Баярсайхан, “Эрүүгийн процессын эрх зүй”, (Уб, 2020), 216 дахь тал.

<sup>22</sup> Мэн тэнд, 217 дахь тал.

<sup>23</sup> UNODC-ийн албан ёсны цахим хуудас, “Adversarial versus inquisitorial legal systems” нийтлэл, Сүүлд үзсэн: 2025.01.08, Холбоос:<https://www.unodc.org/e4j/en/organized-crime/module-9/key-issues/adversarial-vs-inquisitorial-legal-systems.html#:~:text=The%20inquisitorial%20process%20can%20be,defence%20to%20determine%20the%20facts.>

3.7. Хөрөнгө шалгах ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулах тухай зохицуулсан тус хуулийн 52 дугаар зүйл


#### 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн долдугаар бүлэгт “хөрөнгө шалгах ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулах” зохицуулалтыг тусгасан. Тус зохицуулалтад хөрөнгө шалгах ажиллагааны явцад холбогдогч нь хөрөнгийн эх үүсвэрийг хууль бус болохыг хүлээн зөвшөөрч сайн дураар тухайн хөрөнгийг хураалгахыг зөвшөөрсөн тохиолдолд шалгах ажиллагааг дуусгаж, хөрөнгө шалгах ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулахаар хуульчилсан байна. Энэхүү зохицуулалт нь хуулийн төслийн 1.1-д заасан зорилгод хүрч байна гэж үзлээ.

## 2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Төслийн долдугаар бүлэг нь нэг зүйлтэй бөгөөд 52 дугаар зүйлд “Хөрөнгө шалгах ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулах” талаар зохицуулсан байна. Тус зүйлийн зохицуулалтыг практикт хэрэгжих байдлыг үнэлэхэд хөрөнгө шалгах ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулахад хамаарах асуудлыг бүрэн тусгаагүй нь энэхүү зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болгож байна. Нөгөөтээгүүр, хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэсний давуу тал төдийлөн харагдахгүй байгааг дурдах нь зүйтэй. Иймд тус зохицуулалтыг сайтар судлан үзэж, сайжруулах нь зүйтэй.

**Схем 6. Хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа /Хялбаршуулсан журнаар явуулах/**



### 3.8. Шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын тухай зохицуулсан тус хуулийн 53-54 дүгээр зүйл

#### 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн наймдугаар бүлэгт “шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналт”-ыг тусгасан байна. Тус бүлгийн зохицуулалтуудаас үзвэл, шалгах ажиллагаан нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай төстэй бөгөөд эрүүгийн эрх зүйтэй холбогдох байна.

Энэ бүлэгт заасан зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгодоо хүрч байгаа боловч “харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тус хуулийн төслийн эрүүгийн эрх зүйтэй холбогдох зарим зохицуулалтууд зөрчилдөж байгаа асуудал тогтолдсоныг дурдах нь зүйтэй.

**Схем 7. Прокурорын шийдвэр**



#### 2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн наймдугаар бүлэгт:

- 53 дугаар зүйл. Прокурорын шийдвэр
- 54 дүгээр зүйл. Шалгах ажиллагааны хэргийн материал гэх 2 зохицуулалтыг тусгажээ.

Хуулийн төслийн наймдугаар бүлэгт заасан дээрх зохицуулалт нь эрүүгийн эрх зүйд хамааралтай мэт боловч төслийн 53.6-д “Энэ хуульд заасан эвлэрлийн гэрээ

байгуулснаар шалгах ажиллагааг зогсоож болно. Эвлэрлийн гэрээ байгуулах журмыг Улсын ерөнхий прокурорын тушаалаар батална” гэж тусгасан нь ИХШХШТХ-д заасан эвлэрлийн гэрээний агуулгыг илэрхийлж байна.

Учир нь төслийн 53.6-д “энэ хуульд заасан эвлэрлийн гэрээ байгуулснаар” гэж заасан боловч тус зохицуулалтаас өөр эвлэрлийн гэрээтэй холбоотой зохицуулалт хуулийн төсөлд тусгагдаагүй. Нөгөөтээгүүр, ИХШХШТХ-д тусгасан агуулгатай ижил байдлаар тус хуулийн төсөлд тусгасан эвлэрлийн гэрээг сийлгох эсэх нь эргэлзээтэй, байгаагаас шалтгаалан эвлэрлийн гэрээ байгуулахын давуу тал, ач холбогдол, зорилго тодорхойгүй байх тул практикт хэрэгжих боломжийг хязгаарлаж байна.

### 3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн 53, 54 дүгээр зүйлд тус процесс ажиллагаа дахь прокурорын хяналтын бүрэн эрхийг нарийвчлан зохицуулжээ. 53 дугаар зүйлийн 53.1-д “Прокурор шалгах ажиллагааны явцад цугларсан болон гуравдагч этгээдээс ирүүлсэн нотлох баримтад үндэслэн шийдвэр гаргана.” гээд 53.2-т “Хууль бус хөрөнгө байна гэж үзэх хангалттай үндэслэл байгаа бол прокурор тухайн хууль бус хөрөнгийг хураан авах нэхэмжлэл шүүхэд гаргах тухай шийдвэр гаргана.” мөн 53.3-т “Цуглувансан материалд үндэслэн энэ хуульд заасан журмын дагуу хураан авах хууль бус хөрөнгө байна гэж дүгнэх үндэслэлгүй бол прокурор **шалгах ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргана.**” гэж тус тус зааснаас үзвэл тус процесс ажиллагааны (хуулийн төсөлд тус ажиллагааг хэрхэн товчилж нэрийдэх тухайд жигд бус буюу хуулийн төслийн зарим хэсэгт “хөрөнгө шалгах ажиллагаа” гэж зарим тохиолдолд “хөрөнгө хураах ажиллагаа” гэж бичсэн байна) гол хэрэгжүүлэгч нь прокурор хэмээн дүгнэж болохор байна.

Мөн прокурорын энэхүү оролцооны хэлбэр/хяналтын агуулга нь Эрүүгийн процесстой адил байна. Өмнө хэсэгт буюу хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Прокурорын тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан нь прокурор хөрөнгө хураах ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1-д “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд **хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцоно.**” гэж заасан процесс ажиллагааг бүхэлд нь хянах, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцох бүрэн эрхийг шууд эдлэх тухай агуулгатай байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1-д “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” заасан. Энэ нь прокурор эрүүгийн хэрэгт хяналт тавьж шүүхэд яллах байр сууринаас оролцох эсвэл иргэн болон захиргааны шүүхэд төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар нэхэмжлэгчийн байр сууринаас оролцох тухай агуулга юм. Мөн эрүүгийн хэрэгт прокурор шүүхийн шатанд зөвхөн улсын яллагч байх бол иргэн болон захиргааны хэрэгт зөвхөн нэхэмжлэгч тал байх тухай юм. Гэтэл хуулийн төсөлд прокурор шүүхийн өмнөх шатанд эрүүгийн хэрэгт хяналт тавьж буй мэт, харин шүүхийн шатанд нэхэмжлэгч байхаар зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэхгүй байна.

**3.9. Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай зохицуулсан тус хуулийн 55-61 дүгээр зүйл**


#### **1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Хуулийн төслийн есдүгээр бүлэгт “Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа”-тай холбоотой зохицуулалтыг тусгасан байна.

Тус хуулийн төслийн зохицуулалтууд нь иргэний болон эрүүгийн эрх зүйд холбогдох асуудлыг “холимог” байдлаар тодорхойлон тусгасан байна. Тухайлбал, нотлох баримтыг цуглуулах асуудал нь эрүүгийн эрх зүйд холбогдож байгаа бол хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа буюу тухайн асуудлыг иргэний хэргийн шүүх шийдвэрлэхээр заасан.

Энэхүү зохицуулалтууд нь хуулийн төслийн 1.1-д заасан зорилгод нийцэж байгаа боловч иргэн, эрүүгийн эрх зүйн зарчимтай зөрчилдөж байна.

**Схем 8. Иргэний хэргийн шүүх нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх**



Иргэний хэрэг үүсгэсний дараа ИХШХШтХ-д заасан үндэслэлээс гадна хөрөнгө өмчлөгч этгээд холбогдох эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдсан бол тухайн этгээдийн өргөдлийн үндсэн дээр хөрөнгө хураахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж болно.

## **2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Хуулийн төслийн есдүгээр бүлэгт “Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа”-тай холбоотой зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй асуудлууд бий болохоор байна. Тухайлбал, иргэний эрх зүйн харилцаа нь талуудын тэгш эрхийн зарчимд үндэслэдэг болохын хувьд нотлох баримтыг цуглуулах, өөрсдөө нотлох, мэтгэлцэх гэх мэт асуудлууд хөндөгддөг.

Гэтэл хуулийн төсөлд шүүх нь мөрдөгч шалгах ажиллагаа явуулсан хэрэгт прокурор хяналт тавьж, хууль бус хөрөнгө гэж үзэх хангалттай үндэслэл тогтоогдсон гэж үзэн шүүхэд нэхэмжлэл гаргасан хэргийг хянан шийдвэрлэхээр тусгажээ. Энэ нь иргэний хэргийн шүүх иргэний эрх зүйн зарчим, үндэслэлийг баримтлан шийдвэр гаргахад хүндрэлтэй нөхцелийг бүрдүүлэхээр байна..

## **3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Хуулийн төслийн 55-61 дүгээр зүйлд хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай зохицуулсан. **56 дугаар зүйлийн 56.1-д “Шүүхээс хөрөнгө шалгах ажиллагааны явцад цугларсан нотлох баримтыг үндэслэн энэ хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу нэхэмжлэлийг шийдвэрлэнэ.”** гэж заасан нь хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааны шүүхийн шат Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэх буюу иргэний хэргийн шүүх хянан шийдвэрлэх болохыг илтгэж байна.

Судалгааны тайлангийн 3.6 дахь хэсэгт хууль бус хөрөнгө, шалгах, хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаа нь эрүүгийн процессын эрх зүйн шинжтэй хэмээн дүгнэсэн билээ. Эндээс нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааны **шүүхийн өмнөх шат** нь эрүүгийн процессын эрх зүйн шинжтэй зохицуулалттай аталь **шүүхийн шатанд** иргэний процессын эрх зүйн зохицуулалттай хэмээн дүгнэж болохоор байна. Үүнээс энэ процесс ажиллагаа хэрэгжих боломжтой эсэх ч тодорхойгүй болох нь харагдаж байна.

Прокурорын бүрэн хяналт, удирдлага дор явагдах шүүхийн өмнөх шатанд зөвхөн холбогдох бүхий л баримт мэдээллийг, хаанаас ч гаргуулан авах эрхтэй албадлага хэрэглэх ч эрхтэй мөрдөгчийн цуглувансан, бэхжүүлсэн нотлох баримтын хүрээнд иргэний хэргийн шүүх иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэн нэхэмжлэлийг хянан шийдвэрлэнэ гэдэг эрх зүйн онол болоод эрх зүйн тогтолцоонд огт нийцэх боломжгүй явдал юм.

**Хөөн хэлэлцэх хугацаа.** Иргэний хуулийн 9 дүгээр бүлэгт иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох, түр зогсоох, тасалдах, өнгөрсний улмаас үүсэх үр дагаврын зохицуулсан байдаг ба ерөнхий хөөн хэлэлцэх хугацааг 10 жил байхаар тусгай хөөн хэлэлцэх хугацааг гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага бол 3 жил, үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой гэрээний үүрэгт шаардлага бол 6 жил, тогтсон хугацааны туршид гүйцэтгэх үүрэгтэй холбогдон шаардлага бол 3 жил, бусдын эд хөрөнгөд гэм хор учруулснаас үүсэх үүрэгтэй холбоотой шаардлага 5 жил байхаар тус тус заажээ. Хуулийн төслийн 55 дугаар зүйлийн 55.3-т “Хууль бус хөрөнгө хураан авах нэхэмжлэл гаргахад хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй.” гэж заасан Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 75.2-т нийцэхгүй байна.

### **3.10. Олон улсын хамтын ажиллагааны тухай зохицуулсан тус хуулийн 58-62 дугаар зүйл**

#### **1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Хуулийн төслийн аравдугаар бүлэгт “Олон улсын хамтын ажиллагаа”-ны талаарх зохицуулалтыг тусгажээ.

Тус зохицуулалт нь хуулийн төслийн 1.1-д заасан зорилгodoо хүрч байна. Авлигатай тэмцэх, нийтийн албан тушаалтны хууль ёсны орлогын эх үүсвэрээс давсан, түүний шууд болон шууд бус өмчлөл, эзэмшилд байгаа, эрхэлж байсан болон эрхэлж байгаа албан тушаалын эрх нөлөөгөөр бий болсон, хууль ёсны эх үүсвэр тодорхойгүй, эсхүл хууль бус аргаар олж авсан эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлогыг хурааж авах, нөхөн төлүүлэх эрх зүйн үндэслэлийг тогтоо замаар нийтийн алба дахь авлигыг таслан зогсоох, дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, авлигагүй нийтийн албыг бий болгоход олон улсын хамтын ажиллагаа нэн чухал.

Тиймээс ч энэхүү хуулийн төсөлд олон улсын хамтын ажиллагааг тусгасан нь зорилгод хүрэхэд чиглэсэн зохицуулалт болсон байна. Гэхдээ тус зохицуулалтын хувьд “ойлгомжгүй байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэд хэдэн асуудал тогтоогдсон.

#### **Схем 9. Хууль бус хөрөнгө хураан авах /Олон улсын хамтын ажиллагаа/**

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа болон гадаад улсын нутаг дэвсгэрт байгаа хууль бус хөрөнгийг:

- Битүүмжлэх
- Хөрөнгийн хөдөлгөөнийг хязгаарлах
- Түр хураан авах
- Хураан авах тухай Шүүхийн шийдвэр болон Прокурорын шийдвэрийг хангах үүднээс гадаад улстай хамтран ажиллах явдлыг Улсын Ерөнхий Прокурорын газраар дамжуулан уламжилна.

#### **2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Хуулийн төслийн аравдугаар бүлэгт олон улсын хамтын ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тусгасан бөгөөд тус бүлэгт заасан зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй асуудал харьцангуй бага гэж үзлээ. Гэхдээ олон улсын хамтын ажиллагаанд тухайн улс хоорондын эрх зүйн тогтолцоо, хамтын ажиллагаа, хууль тогтоомж гэх мэт олон талт хүчин зүйлс нөлөөлдөг болохын хувьд цаг хугацаа, хөрөнгө санхүү маш их зарцуулдаг. Тиймээс төслийн зохицуулалтын хувьд дээрх асуудлыг хөндөн үзэхгүйгээр практикт хэрэгжүүлэхэд боломжтой зохицуулалт гэж дүгнэсэн болно. Мөн энэ бүлэгт заасан зарим зохицуулалтыг “ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн болно.

### 3.11. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалт нь найруулга, хэл зүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэх мөн логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгах шаардлагатай. Мөн хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ийг баримталсан эсэхийг тусгайлан шалгана. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь дүн шинжилгээ хийлээ.

#### **Хүснэгт 11. Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ**

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1.	Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	Төслийн 1.1-д "...ашиг, орлогыг хурааж авах, нөхөн төлүүлэх..." гэж заажээ.	Тус зохицуулалтын "...хурааж авах, нөхөн төлүүлэх..." гэсний "...хураан авах, нөхөн төлүүлэх" гэж өөрчлөх.
2.	Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт	Төслийн 4.1.1 -д "гэмт хэрэг" гэж нийтийн албан тушаалтны холбогдсон гэмт хэргийг;" гэж заажээ. Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн ойлголттой зөрчилдэж байна.	Тус зохицуулалтыг хасах.
3.	Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт	Төслийн 4.1.3-т "хууль бус орлогоос бий болсон хөрөнгө" гэж хууль бус орлогын үр дүн, үр шимээр бий болсон хөрөнгө, хууль бус орлогоор олсон хөрөнгө, эдгээр хөрөнгийн үр шимээр олсон хөрөнгө, хууль бус орлогын хэлбэр өөрчлөгдхөж юмуу хувирснаас бий болсон хөрөнгийг (хууль бус орлого хууль ёсны хөрөнгөтэй нийлж, хувирч, ёссөн тохиолдолд хууль бус орлогоос бий болсон хэсгээр хязгаарлана.)" гэж тусгасан нь найруулга зүйн алдаатай байна. Мөн тус зохицуулалтад "юмуу" гэх үгийг тусгажээ.	Тус зохицуулалтын найруулгыг засах, мөн "юмуу" гэснийг "эсхүл" гэж өөрчлөх.
4.	Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалт	Төслийн 4.1.13-т "ойрын төрөл, садангийн хүн" гэж гэр бүлийн гишүүн, насанд хүрсэн хүүхэд, эцэг эх (хадам аав/ээж орно), эгч, ах, эмээ, евөө, ач зээ, хүргэн ах, хадам эгч, хадам дүү, бэр, бэр эгч, хүргэн ах, эсхүл тэдний гэр бүлийн гишүүд, эцэг эх, эхнэр/нөхөр/-ийг;" гэж заажээ. Тус зохицуулалтын найруулгыг засаж, зарим нэр томьёог өөрчлөх, давхардсан нэр томьёог хасах.	Тус зохицуулалтын "насанд хүрсэн хүүхэд" гэх нэр томьёог өөрчлөх, "хүргэн ах" гэж давхардуулан бичснийг хасах, , "(хадам аав/ээж орно)", (эхнэр /нөхөр/) гэснийг (хадам аав, хадам ээж), (эхнэр, нөхөр) гэж өөрчлөх нь зүйтэй.
5.	Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.15 дахь	Төслийн 4.1.15-д "...хамаарал бүхий этгээдийн талаархи мэдээллийг..." гэсний	Тус зохицуулалтын "талаархи" гэснийг "

	заалт	алдаа бичсэн үгийг засах.	талаарх" гэж засах.
6.	Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.18 дахь хэсэг	Төслийн 4.1.18-д "...эрүүгийн хуульд заасан..." гэж заажээ.	Тус зохицуулалтын "...эрүүгийн хуульд..." гэснийг "...Эрүүгийн хуульд..." гэж засах.
7.	Төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг	Төслийн 5.3-т "...Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагааг <b>тухайн</b> нийтийн албан тушаалтны шалгагдаж байгаа <b>тухайн</b> хөрөнгөтэй холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай нэг хугацаанд давхардуулан явуулахгүй..." гэж заажээ.	Тус зохицуулалтын "тухайн" гэж хоёр давхардуулан бичсэнийг засах.
8.	Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь хэсэг	Төслийн 6.1.8-д "...хураах ажиллагааг <b>зөвхөн шүүхэд</b> талууд мэтгэлцэх журмаар хэрэгжүүлэх..." гэж заажээ.	Тус зохицуулалтын "зөвхөн" гэх үг нь хүч оруулсан шинжтэй байх бөгөөд тухайн үгийг хассан ч уг зохицуулалтын утга агуулга алдагдахгүй байна.
9.	Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалт	Төслийн 6.1.9-д "...чиг үүрэг дууссанаас <b>хойшхи</b> 10 жилийн хугацаатай..." гэж заажээ.	Тус зохицуулалтын "хойшхи" гэснийг "хойших" гэж засах.
10.	Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалт	Төслийн 6.1.10-т "...хөрөнгийг нөхөн төлбөргүй хураан авах гэм буруугийн үндэслэл гэж үзэх бөгөөд энэхүү санаа зорилгыг..." гэж тусгасан нь ойлгомжгүй байна.	Тус зохицуулалтыг өөрчлөн найруулах.
11.	Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.9 дэх заалт	Төслийн 11.1.9-д "...нөхөн төлүүлэх саналтай <b>прокроурт</b> шилжүүлсэн" гэсний алдаа бичсэн үгийг засах.	Тус зохицуулалтын "прокроурт" гэснийг "прокурорт" гэж засах.
12.	Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг	Төслийн 11.3-т "...Өмгөөлөгч тухайн нийтийн албан тушаалтны өмгөөлөгчөөр оролцох <b>болсноо үйлчлүүлэгчийн бичгээр үйлдсэн хүсэлтээр баталгаажуулж, шүүх, прокурор, мөрдөгчид бичгээр мэдэгдэнэ..." гэж заажээ.</b>	Тус зохицуулалтын найруулгыг засах.
13.	Төслийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг	Төслийн 12.4-т "...Холбогдогчийг шүүхийн шатанд зохигч буюу хариуцагч гэх бөгөөд шүүхийн шатанд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ..." гэж заажээ. Тус зохицуулалтад "шүүхийн шатанд" гэж давхардуулан бичжээ.	Тус зохицуулалтад давхардуулан бичсэн "шүүхийн шатанд" гэх үгийг хасах.
14.	Төслийн 13 дугаар 13.5 дахь хэсэг	Төслийн 13 дугаар зүйлд "Гэрч"-тэй холбоотой зохицуулалтыг тусгасан бөгөөд тус төслийн 13.5-д "Аюулгүй байдлаа хангуулах талаарх хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргана" гэж заажээ.	Тус зохицуулалтын эхэнд "Гэрч" гэж тусгах.
15.	Төслийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг	Төслийн 26.4-т "Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан мэдээллийг гаргаж өгсөн этгээд нь тухайн ажиллагаа явуулсан нууцлалыг хангах үүрэгтэй бөгөөд, зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээн" гэж	Тус зохицуулалтад заасан мэдээллийг гаргаж өгсөн этгээд ажиллагаа явуулсан нууцлалыг хангах

		заасан хэдий ч холбогдох мэдээллийг гаргаж өгсөн этгээд тухайн ажиллагаа явуулсан нууцлалыг хангах үүргээ биелүүлээгүй тохиолдолд ямар хуульд заасан хариуцлага хүлээлгэх талаар зохицуулаагүй байна. Мөн "...бөгөөд, зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ." гэсний "бөгөөд" гэх үгийн ард бичсэн таслалыг хасах.	үүргээ биелүүлээгүй, зөрчсөн тохиолдолд ямар хуулиар хариуцлага хүлээлгэх талаар тодорхой тусгах. Мөн "бөгөөд" гэх үгийн ард бичсэн таслалыг хасах.
16.	Төслийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт	Төслийн 28.1.1-д "...нийтийн албан тушаалтан холбогдсон, Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг хянан хэлэлцэн шүүхийн шийдвэрээр тухайн нийтийн албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдийн хууль бус хөрөнгийг хураагаагүй, эсхүл бүрэн илрүүлж хураагаагүй, эсхүл хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээ хэрэглээгүй бөгөөд энэ хуульд заасан хууль бус хөрөнгө байна гэж үзэх хангалттай үндэслэл байвал..." гэж заасан нь найруулга зүйн алдаатай байна.	Тус зохицуулалтыг өөрчлөн найруулах.
17.	Төслийн 28 дугаар зүйлийн 28.1.2.в дэд заалт	Төслийн 28.1.2.в дэд заалтад "хөөн хэлэлцэх хугацаа" гэж заасан нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл болон Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтад заасан нэр томьёотой нийцүүлэх.	Тус зохицуулалтыг "гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан" гэж өөрчлөх.
18.	Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг	Төслийн 30.1-д "...Хууль бус хөрөнгө шалгах тусгайлласн нэгж нь..." гэснийг алдаа бичсэн үгийг засах.	Тус зохицуулалтын "тусгайлсан" гэснийг "тусгайлсан" гэж засах.
19.	Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг	Төслийн 33 дугаар зүйлийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг "25.1." гэж алдаатай бичсэн байна.	Иймд тус зохицуулалтын "25.1." гэснийг "33.1." гэж өөрчлөх.
20.	Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1.1 дэх заалт	Төслийн 41.1.1-д "...хөрөнгийн үнийг илтэд нөлөөлөх бодит нөхцөл бий болсон..." гэж заажээ.	Тус зохицуулалтын "хөрөнгийн үнийг" гэснийг "хөрөнгийн үнэд" гэж өөрчлөх.
21.	Төслийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг	Төслийн 44.1-д "Хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааны явцад цаашид үнэ цэнээ алдах, төрд ямар нэгэн ашиг өгөхгүй хөрөнгийг битүүмжлэх, хураан авахыг хориглоно." гэж заасан байх бөгөөд тус зохицуулалтад тусгасан "цаашид үнэ цэнээ алдах хөрөнгө" болон "төрд ямар нэгэн ашиг өгөхгүй хөрөнгө" гэх нэр томьёог хэрхэн ойлгож хэрэглэх нь тодорхойгүй байна.	Тус зохицуулалтын "цаашид үнэ цэнээ алдах хөрөнгө" болон "төрд ямар нэгэн ашиг өгөхгүй хөрөнгө" гэх ойлголтыг тодорхой болгох.
22.	Төслийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг	Төслийн 50.1-д "Хөрөнгө шалгах нэгж шалгах ажиллагааны оролцогч болон тухайн ажиллагааны талаар олж мэдсэн бусад этгээдэд шалгах ажиллагааны мэдээллийг зөвшөөрөлгүйгээр задруулахгүй байх үүрэг, үүргээ биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан хариуцлагын талаар	Тус зохицуулалтын "...шалгах ажиллагааны мэдээллийг зөвшөөрөлгүйгээр задруулахгүй байх үүрэг, үүргээ

		мэдэгдэнэ." гэж заасан нь найруулга зүйн алдаатай байна.	биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан хариуцлагын талаар мэдэгдэнэ." гэх хэсгийг өөрчлөн найруулах.
23.	Төслийн 52 дугаар зүйлийн 52.6, 55 дугаар 55.1 дэх хэсэг	Төслийн 52.6 дахь хэсэг, мөн хуулийн 55.1-д "...иргэний хэргийн анхан шатны шүүхэд Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан..." гэж заажээ. Тус зохицуулалтад холбогдох хуулийн нэрийг алдаатай бичсэн байна.	Тус зохицуултад заасан "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд" гэснийг "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд" гэж өөрчлөх.
24.	Төслийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэг, мөн төслийн 60 дугаар зүйлийн 60.2, 60.3, 60.4 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг	Төслийн энэхүү зохицуулалтуудад "Ерөнхий Прокурорын", "Ерөнхий прокурорын" гэж бичсэнийг засах, жигдлэх нь зүйтэй.	Тус зохицуулалтуудад тусгасан "Ерөнхий Прокурорын", "Ерөнхий прокурорын" гэснийг нэг мөр болгон "Улсын ерөнхий прокурор" гэж өөрчлөх.
25.	Төслийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэг	Төслийн 63.1-д "Хууль бус хөрөнгө хураах ажиллагааны цахим мэдээллийн санг прокурорын байгууллага <b>хариуцан эрхлэн</b> хөтөлнө." гэснийг өөрчлөн найруулах.	Тус зохицуулалтын "...хариуцан эрхлэн" гэснийг өөрчлөн найруулах.
26.	Төслийн 63 дугаар зүйлийн 63.2.3 дахь заалт	Төслийн 63.2.3-т "...өмчлөгч, эзэмших чийн" гэж алдаатай бичсэн байна.	Тус зохицуулалтын "...өмчлөгч, эзэмших чийн" гэснийг "өмчлөгч, эзэмшигчийн" гэж засах.
27.	Төслийн 63 дугаар зүйлийн 63.2.4 дэх заалт	Төслийн 63.2.4-т "түр хураасан хөрөнгийг зайлшгүй шаардлагаар худалдан борлуулсан хэлбэр, борлуулснаас олсон орлого, орлого төвлөрүүлсэн данс" гэж заажээ.  Тус зохицуулалтын найруулгыг засах, мөн "түр хураасан хөрөнгийг зайлшгүй шаардлагаар худалдан борлуулсан" гэж заасны "зайлшгүй шаардлага" гэдэгт ямар тохиолдлыг ойлгох талаар нарийвчлан тусгах шаардлагатай.	Тус зохицуулалтын "түр хураасан хөрөнгийг зайлшгүй шаардлагаар худалдан борлуулсан" гэх хэсгийн зайлшгүй шаардлага гэдэгт ямар тохиолдлыг ойлгох талаар нарийвчлан тусгаж, тодорхой болгох, "худалдан борлуулсан хэлбэр, түүнээс олсон орлого" гэж өөрчлөн найруулах.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ**

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын дагуу үнэлгээ хийв.

Ийнхүү үнэлэхдээ уг хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд заасан "Зорилгод хүрэх байдал", "Практикт хэрэгжих боломж", "Ойлгомжтой байдал", "Харилцан уялдаа" гэсэн 4 шалгуур үзүүлэлтийн хүрээнд төслийн үр нөлөөг бүхэлд нь үнэллээ. Мөн тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог тусад нь үнэлж, судалгааны тайланг хүргүүлсэн.

Судалгааны дэлгэрэнгүй дүгнэлт тайлангийн бүлэг тус бүрд тухайлан хийгдсэн учир холбогдох хэсгийн дүгнэлттэй танилцахыг зөвлөж байна.

Хуулийн төслийг бүхэлд нь үнэлсэн учир судалгааны үр дүнг өрөнхийлөн дүгнэсэн болно. Үүнд:

### **Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хувьд :**

Хуулийн төслийн бүлэг тус бүрийн зорилгод хүрэх байдлыг судлан үзсэн бөгөөд зарим бүлгүүдийн хувьд зорилгodoо хүрч байсан бол зарим бүлгүүдийн зохицуулалт зорилгод хүрэх боломжгүй байдлаар тусгагдсан байна. Тухайлбал, хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт заасан хүсэлт, гомдол гаргах зохицуулалтын хувьд зорилгodoо хүрсэн бөгөөд практикт хэрэгжих боломжтой зохицуулалт байна. Гэсэн хэдий ч тус зохицуулалт нь ЭХХШтХ-д заасан хүсэлт, гомдолтой холбоотой зохицуулалттай ижил утга агуулгатай байна.

Харин хуулийн төслийн тавдугаар бүлэгт заасан "хууль бус хөрөнгийг хураан авах ажиллагааны нотлох баримт", зургаадугаар бүлэгт заасан "хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа"-тай холбоотой зохицуулалт хуулийн төслийн зорилгод хүрэхэд хүндрэлтэй гэж дүгнэсэн болно. Дэлгэрэнгүй холбогдох хэсгийн дүгнэлтээс үзнэ үү.

### **Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хувьд :**

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн зарим зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Тухайлбал, хуулийн төслийн зургадугаар бүлэгт заасан "хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа"-тай холбоотой зохицуулалт болох төслийн 28 дугаар зүйлийн 28.1.2.а-д дэд заалт, төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг гэх мэт зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдал тогтоогдож байна.

Энэхүү төслийн зарим зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд төсөв санхүү, хүний нөөц, мэргэшсэн боловсон хүчин, цаг хугацаа, хамтын ажиллагаа гэх мэт олон талт хүчин зүйлс нөлөөлж, хүндрэлтэй асуудлууд тогтоогдож байна. Хуулийн төслийн бүлэг тус бүрийн практикт хэрэгжих боломжийг тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн учир холбогдох хэсгийн дүгнэлттэй танилцана уу.

## **Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хувьд :**

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн ойлгомжгүй зүйл, заалт бүрийг сонгон авч, холбогдох дүгнэлт, саналыг өгсөн болно. /Судалгааны 3.11-д дэлгэрэнгүй тусгасан болно/

## **Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хувьд :**

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл бүхэлдээ зүйл, заалт өөр хоорондын нийцэлгүй, зөрчилдсөн. Мөн түүнчлэн өдгөө хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцэхгүй байна. Түүнчлэн уг хуулийн төслөөр зохицуулагдсан нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаа нь манай улсын үндэсний эрх зүйн тогтолцооны онцлог, уламжлал, дэлхий дахинаа түгээмэл буй эрх зүйн онолд нийцэх боломжгүй байгааг дурдах нь зүйтэй.

Хуулийн төсөл дэх шалгах ажиллагааны зохицуулалт нь талуудын тэгш байдлыг хязгаарлаж, мэтгэлцэх зарчмыг үгүйсгэсэн инквизицийн хэв маягийн эрүүгийн процессын эрх зүйн шинжтэй, харин хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт нь талуудад адил тэгш боломж олгох, мэтгэлцэх зарчмыг процессын бүхий л үе шатанд заавал хэрэгжихийг шаарддаг иргэний процессын эрх зүйн шинжтэй байна. Нэгтгэн дүгнэвэл, хуулийн төслийн зохицуулалт нь эрүүгийн процессын эрх зүй, иргэний процессын эрх зүй хэмээх зохицуулах зүйл болоод зохицуулалтын өөр өөр арга хэрэгсэлтэй бие даасан эрх зүйн салбаруудын зохицуулалтыг “хольж” тусгасны улмаас эрх зүйн суурь зарчмууд хоорондын зөрчилдөөнийг бий болгосон байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр гарах үр нөлөөг тооцсоны үндсэн дээр шаардлагатай бол тухайн хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтыг дахин боловсруулна.” хэмээн заасныг баримтлан Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг ахин шинээр боловсруулах саналыг дэвшүүлж байна.

## **ЭХ СУРВАЛЖ**

### **Хууль тогтоомж, эрх зүйн акт**

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1;
- Гүйцэтгэх ажлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1998), №3;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №24;
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2002), №8;
- Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015), №31;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №7;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №23;
- Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)”
- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”

### **Ном, сурх бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл**

- Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар, 2022 он ;
- Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй Ерөнхий анги, 2004 он;
- Б.Буянхишиг, Иргэний процесс дахь нотолгооны эрх зүй, 2024 он;
- Б.Буянхишиг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, 2021 он;
- Д.Баярсайхан, Эрүүгийн процессын эрх зүй, 2020 он;
- Д.Баярсайхан, Эрх зүйн онол, 2023 он;
- Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, 2024 он;
- Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗДХЯ, 2024 он;
- Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төсөл, ХЗДХЯ, 2024 он;